



**УДИРДЛАГЫН
АКАДЕМИ**

**УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
НИЙГЭМ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
БАЙДЛЫН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

029

Улаанбаатар хот
2021 он

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НИЙГЭМ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ БАЙДЛЫН СУДАЛГАА

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

СУДАЛГААНЫ БАГ

Зөвлөх:

Ц.Баатартогтох

Судалгааны багийн ахлах:

О.Цэрэнчимэд

Судалгааны багийн гишүүд:

Я.Бямбасүрэн

Ж.Жаргал

Ц.Цэгц

Ж.Энхжаргал

Т.Халиун

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	V
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	VI
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	VIII
ӨМНӨХ ҮГ	IX
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	1
1.1. Судалгааны тулгамдсан асуудал.....	1
1.2. Судалгааны асуулт	2
1.3. Судалгааны зорилго	3
1.4. Судалгааны зорилт	3
1.5. Хүлээгдэж буй үр дүн.....	3
1.6. Нэр томъёоны тодорхойлолт	3
ХОЁР. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ.....	5
2.1. Уул уурхайн үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийн тухай ойлголт	5
2.2. Нийгмийн лицензийн онол, үзэл баримтлал	9
2.3. Нийгмийн лицензийг хэмжих судалгааны арга зүй.....	19
2.4. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал	23
2.5. Судалгааны үзэл баримтлал	26
ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	31
3.1. Судалгааны төрөл, түүний зорилго.....	31
3.2. Судалгааны эх олонлог, түүврийг тодорхойлох	31
3.3. Хувьсагч, түүний хэмжигдэхүүнийг тодорхойлох.....	33
3.4. Хүчинтэй ба найдвартай байдал.....	37
3.4.1. Фактор шинжилгээ	37
3.4.2. Найдвартай байдлын шинжилгээ	38
3.5. Өгөгдөл цуглуулах үйл явц	40
3.6. Өгөгдөлд шинжилгээ хийх үйл явц.....	40
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	42
4.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	42
4.2. Монгол хүний уул уурхайд хандах хандлага	45
4.3. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдал	47



4.4. Хамаарлын шинжилгээ	52
4.4.1. Корреляцын шинжилгээ	52
4.4.2. Регрессийн шинжилгээ	54
4.5. Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үр дүн	56
ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ	60
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....	65
ХАВСРАЛТ	67

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ИИ	Институциональ итгэлцэл
МУ	Монгол Улс
НУТХЗБ	Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ОХУ	Оросын Холбооны Улс
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
УУБҮБ	Уул уурхайн бодлогын үзэл баримтлал
ХИ	Харилцан итгэлцэл
ЭЗХЗБ	Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Нийгмийн лицензийг олж авах схем.....	7
Зураг 2.	Нийгмийн лицензийн “пирамид”-ын загвар.....	10
Зураг 3.	Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих хэмжүүр.....	11
Зураг 4.	Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын түвшин ба индикатор.....	12
Зураг 5.	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лицензийн оролцогч талуудын харилцаа	14
Зураг 6.	Нийгмийн лицензийн пирамид загварыг тодорхойлогч хүчин зүйлс	15
Зураг 7.	Үйл ажиллагаа эрхлэн явуулах нийгмийн лицензийн 4 бүрэлдэхүүн хэсэг.....	17
Зураг 8.	Оролцогч талуудын харилцааг тодорхойлогч нийгмийн лицензийн гурван түвшний дөрвөн хүчин зүйл.....	19
Зураг 9.	Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын түвшин тус бүрт оролцогч талуудын эзлэх хувиар хүчин зүйлсийн харилцааны өөрчлөлтийг харуулсан загвар	20
Зураг 10.	Судалгааны үзэл баримтлалын хүрээ	27
Зураг 11.	Нийгмийн лицензийг бүрдүүлэгч хүчин зүйлс.....	28
Зураг 12.	Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлсон зураглал.....	29
Зураг 13.	Монгол улсын сонгуулийн насны хүн амын тоогоор түүврийн хэмжээг тодорхойлсон байдал.....	32
Зураг 14.	Судалгаанд оролцсон нийслэл хот, орон нутгийн иргэдийн хувь, насаар харьцуулсан байдал	42
Зураг 15.	Судалгаанд оролцсон иргэдийн хүйсийн байдал нийслэл хот, орон нутгаар	43
Зураг 16.	Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн боловсролын түвшин	43
Зураг 17.	Судалгаанд оролцсон Дорнод аймгийн иргэдийн боловсролын түвшин	44
Зураг 18.	Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн ажил эрхлэлтийн байдал.....	44
Зураг 19.	Судалгаанд оролцсон Дорнод аймгийн иргэдийн ажил эрхлэлтийн байдал.....	45
Зураг 20.	Монгол хүний уул уурхайд хандах хандлага хот, хөдөөгөөр.....	46

Зураг 21.	Судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын хүчин зүйлсийг үнэлсэн байдлын харьцуулалт нийслэл хот, орон нутгаар (судалгааны арга 1).....	49
Зураг 22.	Улаанбаатар хотын иргэдийн нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээгээр тооцоолсон пирамидын зураглал (судалгааны арга 1)	50
Зураг 23.	Дорнод аймгийн иргэдийн нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээгээр тооцоолсон пирамидын зураглал (судалгааны арга 1)	51



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Нийгмийн лицензийн онооны хүрээ	21
Хүснэгт 2.	Нийгмийн лицензийг хэмжих 12 асуултын загварчлал	22
Хүснэгт 3.	Нийслэл хотын 9 дүүргийн сонгуулийн насны иргэдийн тоо	23
Хүснэгт 4.	Дорнод аймгийн 4 сум, дүүргийн сонгуулийн насны иргэдийн тоо	32
Хүснэгт 5.	Нийгмийн лицензийг хэмжих концептуализаци/операционализаци	33
Хүснэгт 6.	Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих асуултууд	34
Хүснэгт 7.	Монгол улс дахь нийгмийн лицензийн онооны хүрээ	36
Хүснэгт 8.	Монгол хүний уул уурхайд хандлагыг хэмжих асуултууд	36
Хүснэгт 9.	Хүчинтэй ба дотоод нийцтэй байдлын шинжүүрийн үр дүн	37
Хүснэгт 10.	Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг хэмжих хүчин зүйлсийн найдвартай байдал	39
Хүснэгт 11.	Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг хэмжих асуултуудын Кронбах Альфа утга	39
Хүснэгт 12.	Нийгмийн лицезийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих асуултуудын Кронбах Альфа утга	40
Хүснэгт 13.	Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих асуултуудын Кронбах Альфа утга	40
Хүснэгт 14.	Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлох асуултуудын дундаж оноо хот, хөдөөгөөр	45
Хүснэгт 15.	Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлох асуултуудын дундаж үнэлгээ нийслэл хот, орон нутгаар	47
Хүснэгт 16.	Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын онооны хүрээ (судалгааны арга 2)	52
Хүснэгт 17.	Улаанбаатар хотын иргэдийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн харилцан корреляцын коэффициент	53
Хүснэгт 18.	Дорнод аймгийн иргэдийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн харилцан корреляцын коэффициент	54
Хүснэгт 19.	Улаанбаатар хотын иргэдийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүчин зүйлсийн регрессийн шинжилгээний үр дүн	55
Хүснэгт 20.	Дорнод аймгийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүчин зүйлсийн регрессийн шинжилгээний үр дүн	55

ӨМНӨХ ҮГ

Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн судалгааны баг “Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдал”-ын судалгааны тайлангаа уншигч та бүхэнд толилуулж байна.

Монгол Улс 1990 онд ардчилсан нийгэмд шилжих үйл явцтай зэрэгцэн эдийн засгийн чөлөөт зах зээлийн тогтолцоотой болсноор уул уурхайн салбарын хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа огцом өсч, эдийн засагт эзлэх хувь хэмжээ жил бүр нэмэгдсээр байна. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа өнөөдөр улсын төсвийн орлогын 30 орчим хувийг, дотоодын нийт бүтээгдэхүүний 18.6 хувийг, экспортын орлогын 80 орчим хувийг бүрдүүлж байна. 2020 оны эхний 10 сард нийт 143 улстай худалдаа хийсэн хэдий ч нийт бараа эргэлтийн 58.1 хувийг БНХАУ эзэлж байна. БНХАУ-д хийсэн худалдаа нь манай улсын нийт экспортын 73.8 хувийг, импортын 36.8 хувийг тус тус эзэлж байна. Экспортын бүтээгдэхүүний 38.0 хувийг чулуун нүүрс, 30.5 хувийг зэсийн баяжмал эзэлж байна. Харин Швейцар улсад экспортолсон барааны 99.8 хувийг, Сингапур улсад экспортолсон барааны 45.5 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 58.1 хувийг алт эзэлж байна (Үндэсний статистикийн хороо, 2020, хууд. 13).

Уул уурхайн үйл ажиллагааны ач холбогдол эдийн засагт чухал болохын хэрээр салбарын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тухайлсан уул уурхайн үйл ажиллагааны нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх, байгаль орчны менежмент, нөхөн сэргээлтийг сайжруулах асуудал олон нийтийн хүрээнд хэлэлцэгдэх болсон. Тус салбарын үйл ажиллагааг олон нийт хүлээн зөвшөөрөх буюу “Social License-Нийгмийн лиценз”-ийн тухай судлах хэрэгцээ нэмэгдэж эхлээд байна. Уул уурхайн салбарын нийгмийн лицензийг олгох ерөнхий хандлага, тухайлсан бүс нутгийн иргэдийн нийгмийн лиценз олгох төлөв байдлыг судлаач Иан Томсон, Роберт Бутилер болон Блэк Лийорагийн арга зүйг ашиглан энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

Уул уурхайн салбарын нэгэн чухал ойлголт бол үйл ажиллагааны оролцогч талуудын харилцаа юм. Уул уурхайн үйл ажиллагааны хүрээнд оролцогч талуудыг анхдагч болон хоёрдогч гэж ангилж, уурхайн үйл ажиллагаа эрхлэх орон нутгийн хүн амыг “анхдагч” буюу “үндсэн” оролцогч тал, олон нийтийг “хоёрдогч” оролцогч тал гэж нэрлэдэг байна. Иймээс судалгааны түүврийн дагуу 1510 иргэнийг хамруулсан бөгөөд 1106 иргэн нийслэл хотоос, 404 иргэн хөдөө, орон нутгийн буюу Дорнод аймгийн Хэрлэн, Баяндун, Дашбалбар, Матад сумдын иргэдийг судалгаанд хамруулсан болно.

Судалгааны хүрээнд нийгмийн лиценз олж авах суурь нөхцөл нь эдийн засгийн хүчин зүйл гэдэг нь тодорхой болсон. Харин Улаанбаатар хотын иргэдийн нийгмийн лицензийн дөрвөн үзүүлэлтийг Дорнод аймгийн иргэдийн

үзүүлэлтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь хотын иргэд уул уурхайн үйл ажиллагаанаас шууд эдийн засаг, нийгмийн хамаарал бага байгааг илэрхийлж байв. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын үзүүлэлт түтгэлзэх түвшинг давсан төдий байгаа нь судалгаанд оролцогчид төрийн байгууллага албан ёсоор зөвшөөрсөн учир хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй гэсэн ойлголт, хандлагатай байна.

Энэхүү судалгааны ажлыг хийх боломжийг олгосон Удирдлагын академийн Эрдмийн зөвлөл, Ашигт малтмал, газрын тосны газар болон бусад хамтран ажилласан хүмүүст судалгааны багийн өмнөөс талархал илэрхийлж байна.

Уншигч та бүхнээс судалгааны тайланг анхаарал хандуулан уншихыг хүсье. Та бүхэн энэхүү судалгааны ажлын хүрээнд санал, шүүмж, зөвлөгөөгөө Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимд (tserenchimed@naog.gov.mn) цахим хаягаар, эсвэл 70135535 утсаар холбоо барьж ирүүлнэ үү?

Судалгааны багийн ахлах
Доктор О.Цэрэнчимэд

АБСТРАКТ (ХУРААНГУЙ)

Уул уурхайн салбарын нийгмийн лицензийн олгох ерөнхий хандлага, тухайлсан бүс нутгийн иргэдийн нийгмийн лиценз олгох төлөв байдлыг судлаач Иан Томсон, Роберт Бутилер болон Блэк Лийорагийн арга зүйг ашиглан “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “харилцан итгэлцэл”, “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “институциональ итгэлцэл” гэсэн дөрвөн хэмжээсээр задлан үнэлсэн бөгөөд судалгаанд оролцогчийн хандлагыг уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт, аминч үзэл, оролцоо, өөртөө итгэх итгэл, бусдад итгэх итгэл, гадны хүнд итгэх итгэл гэсэн хэмжигдэхүүнээр судлан үзсэн. Судалгаанд 1510 иргэнийг хамруулсан бөгөөд 1106 иргэн нийслэл хотоос, 404 иргэн хөдөө, орон нутгийн буюу Дорнод аймгийн Хэрлэн, Баяндун, Дашбалбар, Матад сумдын иргэд байсан.

Судалгаагаар “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “институциональ итгэлцэл” хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрээгүй, “харилцан итгэлцэл” болон “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” хүлээн зөвшөөрөхүйц хэмжээг дөнгөж давсан үзүүлэлттэй байна. Уул уурхайн үйл ажиллагааны нийгмийн лиценз улаан бүсээс ногоон бүс хооронд хэлбэлзэж, цуцлагдах эрсдэл өндөр байна. Аминч үзэл, оролцоо, бусдад итгэх итгэл нийгмийн лицензийг олгоход хүчтэй хамааралтай байгаа бол өөртөө итгэх итгэл, гадны хүнд итгэх итгэл хэсэгчилсэн хамааралтай байна. Нийгмийн лицензийн өөрчлөлтийн 79.5 хувь нь уул уурхайд хандах иргэдийн хандлагаас хамаарч байна.

1.1. Судалгааны тулгамдсан асуудал

Төрийн удирдлага засаглалыг хэрэгжүүлэхдээ улс төрийн шийдвэр, төрийн бодлогоор зохицуулалт хийж, нийгмийн оролцогч талууд болох ТӨР-ИРГЭН-ХУВИЙН ХЭВШЛИЙН харилцаа хамтын ажиллагааг тодорхойлж өгдөг. Энэ зохицуулалт нь үндсэн хуулиар тодорхойлогдсон *“Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв санааны нэгдлийг хангах, хууль дээдлэх”* үндсэн зарчмыг баримтлах ёстой. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаанд оролцогч талууд дээрх зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй юм.

Уул уурхайн салбарын нэгэн чухал ойлголт бол үйл ажиллагааны оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагаа юм. Оролцогч тал гэх ойлголт нь нэлээд түгээмэл хэдий ч нийгэм, олон нийтийн хүрээнд ялгаатай байдлаар нарийвчлан авч үздэг судлагдахуун юм. Уул уурхайн үйл ажиллагааны хүрээнд оролцогч талуудыг анхдагч болон хоёрдогч гэж ангилан үйл ажиллагаа явуулах орон нутгийн хүн амыг “анхдагч” оролцогч тал буюу “үндсэн” оролцогч тал гэж нэрлэдэг байна. Жишээлбэл, аймаг, сумын удирдлага, улс төрч, худалдаа болон үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, нийгмийн тодорхой сонирхлын бүлгүүд, байгаль орчныг хамгаалагчид, нутгийн зөвлөл, хэвлэл мэдээлэл зэргийг үүнд багтаан ойлгодог. Тухайлбал, ашигт малтмалын тухайн хуулийн 42.1-р заалтаар “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” *хэмээн хуульчилсан байна* (Ашигт малтмал газрын тосны газар 2019). Хэдийгээр уул уурхайн салбарын үйл ажиллагаа Монгол улсын эдийн засагт тэргүүлэх байр сууртай ч өөрийн хөгжлийн явцад оролцогч талуудын эрх ашгийг тэгш хангах тал дээр асуудалтай тулгарч, нийгмийн харилцан ойлголцол муудсаар байна. Нийгмийн харилцагч талуудын харилцан хамаарлын асуудлыг улс төр судлалд бодлого судлал авч үздэг (П.Доржсүрэн, Я.Бямбасүрэн, 2006, хууд. 7). Бодлого судлал нь орчин үеийн дэвшилтэд технологийн хөгжлийн хурдыг дагалдсан нийгмийн олон талт харилцаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход анхаарч байна.

Монгол Улсын хувьд 1990 онд ардчилсан нийгэмд шилжин эдийн засгийн чөлөөт зах зээлийн тогтолцоотой болохтой зэрэгцэн уул уурхайн салбарын хайгуул, олборлолт огцом өсч, эдийн засагт эзлэх хувь хэмжээ жил бүр бүр нэмэгдэж байна. Тухайлбал, “Алт-1” болон “Алт-2” хөтөлбөр”-ийг 1992-2000 оны хооронд хэрэгжүүлж, 600 гаруй орд газарт хайгуулын үйл ажиллагаа



эрхэлж, 200 гаруй ордыг өнөөгийн байдлаар ашиглаж, улс төсвийн орлогын 30 орчим хувийг, дотоодын нийт бүтээгдэхүүний 18.6 хувийг, экспортын орлогын 80 орчим хувийг бүрдүүлж байна (УУБҮБ-ын үнэлгээний цуврал тайлан 2017). 2020 оны эхний 10 сард нийт 143 улстай худалдаа хийсэн хэдий ч нийт бараа эргэлтийн 58.1 хувийг БНХАУ эзэлж байна. БНХАУ-д хийсэн худалдаа нь манай улсын нийт экспортын 73.8 хувийг, импортын 36.8 хувийг тус тус эзэлж байна. Түүнчлэн тус улсад экспортолсон бараа бүтээгдэхүүний 38.0 хувийг чулуун нүүрс, 30.5 хувийг зэсийн баяжмал эзэлж байна. Харин Швейцар улсад экспортолсон барааны 99.8 хувийг, Сингапур улсад экспортолсон барааны 45.5 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 58.1 хувийг алт эзэлж байна (Үндэсний статистикийн хороо, 2020, хууд. 13). Өөрөөр хэлбэл, Монгол Улсын экспорт уул уурхайн салбараас хүчтэй хамааралтай байна.

2017 оны Уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээний тайлангаас авч үзвэл тус салбарын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт дундаж, салбарын үйл ажиллагааны нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөжийн оновчлол дундаж, уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны менежмент муу гэсэн үнэлгээтэй байна. Тус салбарын үйл ажиллагаа иргэдэд хүлээн зөвшөөрөгдөх буюу “Social License-Нийгмийн лиценз”-ээмшилт сул байна. Үүний нэг үндэслэл нь уул уурхайн салбарын талаар үндэслэлгүй мэдээ, мэдээллийг нийгэмд хурдан түгээх, салбарын үйл ажиллагааны оролцогч талууд асуудлыг өөр өөрсдийн өнцгөөр тайлбарлах, ашигт малтмалын хуулийн хэрэгжилт сул байгаатай холбоотой. Иймээс нийгмийн харилцаанд оролцогч талуудын харилцан итгэлцэх нөхцөл байдлыг уул уурхайн үйл ажиллагааны хүрээнд тодруулах, иргэдийн уул уурхайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх байдлыг хэмжих, тус салбарын бодлогын хэрэгжилтийг үнэлэх тулгамдсан хэрэгцээ бий болоод байна.

1.2. Судалгааны асуулт

- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг авах нь иргэдийн уул уурхайд хандах хандлагатай шууд хамааралтай байна уу?
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг олж авахад нөлөөлөх гол хүчин зүйлс нь юу вэ?
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензэд нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан хамааралт байдал Монгол улсад ямар түвшинд байна вэ?

1.3. Судалгааны зорилго

Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг олж авахад нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан хамаарлыг тодруулахад чиглэгдэнэ.

1.4. Судалгааны зорилт

- Уул уурхайн салбарын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг судлах,
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг олж авахад нөлөөлөх хүчин зүйлсийг судлах,
- Уул уурхайн үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг олж авахад нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан хамааралт байдлыг судлах,
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг олж авах үйл явц, иргэдийн уул уурхайд хандах хандлагын харилцан хамааралт байдлын өнөөгийн нөхцөлийг тайлбарлахад чиглэгдэнэ.

1.5. Хүлээгдэж буй үр дүн

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лицензийг олж авах үйл явц, нийгмийн лицензийг олж авахад нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан хамааралт байдалд үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулна.

1.6. Нэр томъёоны тодорхойлолт

Судалгааны ажлын хүрээнд Монгол хүний уул уурхайд хандах хандлага болон уул уурхайн үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлсон нэр томъёонууд нь дараах тодорхойлолтуудаар тайлбарлагдана.

Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч хүчин зүйлс:

“Аминч үзэл” нь бусдын хохирч буйг үл тоомсорлон өөрийн сайн сайхан, ашиг тусын төлөө санаа тавих гэж толь бичигт тайлбарлагдана [Merriam-Webster 1928].

“Оролцоо” нь оролцох үйлийн нэр, туслалцаа, хамжилцаа гэж монгол хэлний толь бичигт тайлбарладаг (Я.Цэвэл 2021). Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд иргэдээс асуух ёстой гэсэн утгаар тодорхойлогдоно.

“Итгэлцэл”: Хувь хүний хувьд “итгэлцэл” нь хүмүүс бусдад найдаж, тэднийг өөрт нь халдах боломжийг олгохдоо бэлэн байгаа хэмжээ гэж тайлбарладаг (Ноу 2000). Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч хүчин зүйлд өөртөө итгэх итгэл, бусдад итгэх итгэл, гадны хүнд итгэх итгэлийн хүчин зүйлсээр тодорхойлсон болно.

Уул уурхайн үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг тодорхойлогч хүчин зүйлс:

“Нийгмийн лиценз” нь нийтийн сайн сайхан (нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчин) байдалд тухайн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн бий болох эсвэл болж байгаа тодорхой үр нөлөөнд үндэслэн оролцогч талуудын сүлжээ буюу олон нийтийн зүгээс өгч байгаа зөвшөөрөл эсвэл зөвшөөрөл өгөхөөс түдгэлзэх үйлдэл, эс үйлдэл юм” гэж тодорхойлсон байдаг (Cooney 2017).

“Оролцогч талууд” нь зөвхөн орон нутгийн иргэдээр хязгаарлагдахгүй. Төрийн бус байгууллага, сонирхлын бүлгүүд, үйлдвэрчний эвлэл, шашны бүлэглэл, хэвлэл мэдээлэл, илүү өргөн хүрээтэй олон нийтийг багтаасан оролцогч талуудтай гэж тодорхойлсон байдаг (Morrison 2014).

“Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” нь төсөл/аж ахуйн нэгжээс хүлээн авагчдад/нутгийн иргэдэд/ ашиг тусаа өгч байгааг хүлээн зөвшөөрсөн төлөв байдал юм (Boutilier 2011).

“Харилцан итгэлцэл” нь талууд харилцан сонсдог, хариу өгдөг, амлалтаа биелүүлдэг, яриа хэлэлцээрт хийдэг, хамтран ажиллах, өөрийн орон зайд нэвтрэхийг зөвшөөрөх төлөв байдал юм (Ian Tomson, Robert G. Boutilier 2011).

“Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” нь төсөл/аж ахуйн нэгж нь бус нутгийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулдаг, орон нутгийн амьдралын хэв маягийг хүндэтгэдэг, нийгэмд гүйцэтгэх үүргийнхээ талаарх хүлээлтийг хангаж, оролцогч талуудтай шударга ёсны үзэл бодлын дагуу ажилладаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн төлөв байдал юм (Ian Tomson, Robert G. Boutilier 2011).

“Институциональ итгэлцэл” нь оролцогч талууд тухайлбал, олон нийтийн төлөөллийн байгууллагууд ба төсөл/аж ахуйн нэгжийн хоорондох харилцаа нь бие биенийхээ ашиг сонирхлыг тогтвортой анхаарах институци бий болсон бөгөөд түүнийг зөв сайн ажиллаж байгаад бүх холбогдогч талууд итгэл үзүүлэх төлөв байдал юм (Ian Tomson, Robert G. Boutilier 2011).

ХОЁР. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

2.1. Уул уурхайн үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийн тухай ойлголт

Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лиценз буюу **“Social License to Operate”** хэмээх ойлголтыг зарим тохиолдолд **“Social License”** хэмээн “Нийгмийн лиценз” гэсэн нэр томъёогоор хэрэглэж байна. Энэ “нийгмийн лиценз” гэх нэр томъёо нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэх, төслөө хэрэгжүүлэхэд шаардагдах албан ёсны зөвшөөрлөөс өргөн цар хүрээтэй ойлголт юм. Нийгмийн лиценз гэсэн нэр томъёог хамгийн анх 1818 онд английн сүмийн номлогч Жон Уильям Каннингэм ашигласан юм. Тэрээр нийгмийн лиценз гэсэн нэр томъёог хүндэтгэлийн өдрийг зохих ёсоор хүндэтгэж чадаагүй хүний зан үйлийг дүрслэхдээ ашиглаж байжээ. Харин “нийгмийн лиценз”-ийн орчин цагийн утга санааг нэг цаг үед хоёр өөр хүн бие даан гаргаж ирсэн нь В.Мур болон Жим Куны нар юм. Тодруулбал, 1996 онд В.Мур “нийгмийн лиценз” гэсэн ойлголтыг цаас үйлдвэрлэх салбарын нэр томъёо болгон ашиглаж байсан нь цаас үйлдвэрлэдэг компаниуд “нийгмийн лиценз”-ээ хадгалж үлдэхийн тулд байгаль орчны талаарх дүрэм журмыг давж гарах ёстой гэж үзсэн байдаг (Moore 1996).

Харин Ж.Куни уул уурхайн салбарт “нийгмийн лиценз”-ийг олж авахыг хууль ёсны лицензтэй адилтган үзсэн. Тэрээр 1990-ээд оны сүүлчээс уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүд улс төр, нийгмийн эрсдлээ удирдахад бэрхшээлтэй байгааг, түүнчлэн засгийн газар уул уурхайн хууль ёсны лиценз олгох үйл явцад засгийн газраас олон нийтийн ашиг сонирхлыг анхааралдаа авч, хамгаалах чадваргүй байгааг олж харсан байдаг (Cooney 2017). Ж.Кунийн судалгаа В.Мураас ялгаатай нь хүрээлэн буй орчныг хамгаалах ажилд бус, харин олон нийтийн сайн сайхан байдалд чиглэдэг. Тиймээс олон нийтийн эсэргүүцлийг бий болгоод байгаа төр засгийн бүтэлгүйтлийг нөхөхийн тулд уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжүүд “нийгмийн лиценз” гэсэн ойлголтыг олон нийт, орон нутгийн иргэдээс олж авах ёстой гэж тэрээр зөвлөсөн. Ж.Куни “нийгмийн лиценз” гэдэг ойлголтыг оролцогч талуудын харилцан хамаарал буюу олон нийтийн зүгээс нийтийн сайн сайхан байдал (нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчин)-д тухайн бизнесийн үйл ажиллагаа харилцан ач тустай байх асуудлыг үндэслэн зөвшөөрч байгаа явдал” хэмээн тодорхойлдог. Жон Моррисон “Нийгмийн лиценз нь тогтсон тодорхойлолт, ямар нэгэн стандарт загваргүй ойлголт бөгөөд орон нутгийн иргэд ямар нэгэн төслийг хүлээн зөвшөөрөх тухай асуудал” юм гэжээ (Morrison 2014). Өөрөөр хэлбэл, төр



засгийн олгосон үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөл буюу “лиценз” гэх ойлголтоос гадна тухайн үйл ажиллагаа эрхлэхийг бүс, орон нутгийн иргэд (public) хүлээн зөвшөөрөх тухай асуудал гэж үзсэн байна. Хэдийгээр төр засаг зөвшөөрч, хууль ёсны лиценз олгосон төсөл байсан ч иргэд (олон нийт/public) болон оролцогч талууд саад учруулах чадвартай гэсэн санааг тусгадаг.


1997 оны 5-р сард Дэлхийн банкны төлөөлөгчид Эквадорт болсон уул уурхайн нийгэмлэгийн бага хурал дээр “нийгмийн лиценз” гэх нэр томъёог Ж.Кунигийн агуулгаар ашигласан нь уул уурхайн салбарт энэ ойлголтыг түгээх үндэс болжээ. Ихэнх хүмүүс уул уурхайн салбарын үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах, ашигт малтмалын нөөц ашиглахыг эсэргүүцэх нь иргэний нийгмээс ихтэй гэж боддог. Харин уул уурхайн салбарын үйл ажиллагаанд нийгмийн лицензийг олж авах тухай энэ үзэл баримтлал нь 1990-ээд оны сүүлээр эхлэсэн бөгөөд ХУВИЙН ХЭВШЛИЙН аж ахуйн нэгжүүд улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд өөрсдийн үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, бүс болон орон нутгийн хэмжээнд хариуцлагатай уул уурхай эрхлэх боломж гэж судлаачид үздэг (Cooney 2017).

1997 оны Дэлхийн банкны бага хурлын үеэр “нийгмийн лиценз”-ийн тухай ойлголтыг яагаад нэвтрүүлэх ёстой болохыг тэрээр тайлбарлахдаа: *“НИЙГМИЙН ЛИЦЕНЗ” нь оролцогч талуудын харилцан хамаарал буюу олон нийтийн зүгээс нийтийн сайн сайхан (нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчин)-д тухайн бизнесийн үйл ажиллагаа үр дүнтэй хувь нэмэр оруулдаг байх асуудлыг үндэслэн зөвшөөрч байгаа явдал юм*” хэмээн тодорхойлжээ (Cooney 2017). Өөрөөр хэлбэл, нийгмийн лиценз гэдэг нь тухайн үйл ажиллагаа нийгэм-улс төр, соёлын харилцан хамаарал, эдийн засгийн үр ашигтай, хүрээлэн буй байгаль орчинд нөлөөлөл багатай гэдгийг бүс нутгийн иргэд эсвэл улс орны хэмжээнд иргэд нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөх тухай асуудал юм. Энэ нь бүх оролцогч талуудын оролцоог хангах замаар харилцан ашигтай байдлыг үйл ажиллагаанд тусгах буюу бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлалаар “бүх талуудын оролцоог хангах зарчмыг” мөрдөж ажиллах нь үйл ажиллагааны үүрэг юм (Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, 5.1.13-р заалт). Өөрөөр хэлбэл, бүх талуудыг оролцоог хангах гэдэг нь оролцогч хүн бүрийн саналыг тусгах гэсэн үг биш бөгөөд харилцан ач тустай хамтран ажиллах тухай асуудал юм.

Уул уурхайн үйл ажиллагаанд нийгмийн лиценз олж авах, түүний байр суурийг (статус) олон нийтийн хүрээнд хадгалах, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тогтмол сайжруулах нь бизнес эрхлэгчдийн гол зорилго юм. Энэ асуудал нь компани эсвэл уул уурхайн хэрэгжүүлж байгаа тодорхой төслийн талаарх олон нийтийн ойлголттой шууд хамааралтай байдаг. Тухайлбал, уул уурхайн үйл ажиллагааны чанарыг хэмжих олон улсын жишиг нь тухайн уул уурхайн үйл ажиллагааг иргэдийн зүгээс түтгэлзүүлэх эсвэл нийгмийн хэмжээнд бүс, орон нутагт болон улсын түвшинд хүлээн зөвшөөрч, нийгмийн

лиценз олгох тухай асуудал юм. Нийгмийн лиценз нь үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцан итгэлцэл, ойлголцол дээр суурилах бөгөөд зарим тохиолдолд олон нийтийн зүгээс хамтран өмчлөх хэлбэр нь үйл ажиллагаанд нийгмийн лиценз олгох урьдчилсан нөхцөл болж өгдөг талтай (Зураг 1).

Зураг 1. Нийгмийн лицензийг олж авах схем



Эх сурвалж: (Ian Thomson, Joyce Susan, 2008)

Нийгмийн лицензийг олж авах буюу нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх гэдэг нь тухайн салбарын үйл ажиллагаа эрхлэгчид болон бус нутаг, орон нутгийн иргэдийн харилцан итгэлцлийн тухай асуудал юм. Оролцогч талуудын итгэл үнэмшил, ойлголт болон хандлагаас хамаарч харилцан итгэлцэлтэй нөхцөлд хамтран өмчлөх, харин илтгэлцэл алдрах нөхцөлд илтгэлцлийн легитим чанар алдагдаж, хүлээн зөвшөөрч байсан нийгмийн лицензээс татгалзах тухай асуудал гарч ирдэг.

Нийгмийн лицензийн легитим чанар нь хууль ёсны зөвшөөрөл болон нийгэм дэх соёлын харилцаан дээр тогтсон хэм хэмжээнд суурилдаг. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компаниуд олон нийтийг буюу иргэдийг ойлгодог байх ёстой юм. Учир нь үйл ажиллагааны хүрээнд бүс, орон нутгийн иргэд нийгмийн харилцаанд “тоглоомын дүрэм” нөлөөлдөг. Олон нийт байнга хамтран ажиллах чадварыг тэднээс шаардаж байдаг. Хэрэв үйл ажиллагаанд олон нийтийн зүгээс харилцан итгэлцэл бүрдэхгүй үед нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаанд хамтран ажиллахаас иргэд татгалзаж эхлэдэг.



Нийгмийн лицензийн легитим чанар нь бодит нөхцөлд нийгмийн бүх гишүүдтэй харилцах, төсөл хөтөлбөрийн тухай үнэн зөв ойлголт өгөх, аж ахуйн нэгжүүд ирээдүйд бүс, орон нутагт ямар эрсдэл үүсэж болохийг зөв мэдээлэх, улмаар үйл ажиллагаандаа нээлттэй байх асуудлыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, оролцогч талууд нь хууль ёсны тэгш эрхтэйгээр нийгмийн харилцаанд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх үүрэгтэй гэсэн үг юм. Нийгмийн лицензийн легитим чанар нь харилцан итгэлцлийн чанарыг илэрхийлэх бөгөөд суурь ойлголт юм. Учир нь мэдээлэл үнэн зөв, тодорхой байх, нийгэмд хүлээгдэж байгаа үүргээ биелүүлэх замаар голчлон харилцан итгэлцэл бий болдог жамтай. Итгэлцэлтэй нэгдмэл ойлголтоор нийгэм, олон нийт уул уурхайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, нийгмийн лицензийг олгодог. Ихэнхдээ үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд нь нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг харилцан тохиролцох замаар тодорхойлж, нэгтгэн албажуулж хэрэгжүүлнэ. Энэ агуулгыг 2006 оны ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 42.1-р заалтаар “нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулах” буюу орон нутгийн төрийн байгууллага хариуцлагатай ажиллах үүрэгтэй болж, мөн 42.2-р заалтаар “нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг хийх” буюу төр, хувийн хэвшил хамтран ажиллах, тухайн үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлж байх үүрэгтэй гэж томъёолж шинэчилсэн байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид нь албан ёсны гэрээг хариуцлагатай хэрэгжүүлэн илүү найдвартай байдлыг бий болгохыг хичээж, оролцогч талуудтай итгэлцлийг урт хугацаанд хадгалахыг хүсдэг. Энэ хэлбэр нь олон нийтийн хүлээлтийг удирдахад тусалдаг бөгөөд үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах механизм болж өгдөг.

Итгэл хүлээлгэх байдлаас хамаарч үүссэн нийгмийн лицензийн зөвшөөрөл нь харилцааны маш чухал чанарын үзүүлэлт юм. Үүнийг бий болгоход оролцогч талуудад цаг хугацаа, харилцан хүчин чармайлт шаардагддаг. Энэ асуудлыг судлаач Жон Моррисон өөрийн бүтээлдээ “нийгмийн лиценз”-ийн урьдач нөхцөл хэмээсэн байдаг (Morrison, The social license: How to keep your organization legitimate 2014). Бодит итгэлцэл нь хамтын ажиллагаанд хуваалцсан туршлагаас үүсэх хэдий ч үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн хувьд олон нийтийн итгэлцлийг нэмэгдүүлэх замаар нийгмийн лицензийг хамтран өмчлөх боломжтой юм. Энэ хэлбэр нь уул уурхайн хувьцаа эзэмших, хувьцааны ноогдол ашиг хүртэх зэрэг байдлаар илэрдэг. Тухайлбал, Монгол Улсын хувьд улс төрийн шийдвэрээр Эрдэнэс ТТ ХХК-ийн 1072 ширхэг хувьцааг иргэн бүрд эзэмшүүлсэн байдаг. Харин тухайн хувьцаа эзэмшигчийн зүгээс итгэл хүлээлгэх эсэх асуудал иргэдийн итгэл үнэмшил, хандлагаас хамаарч уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдэд нийгмийн лицензийг олгох эсвэл түдгэлзэх нь өөрөө урт хугацааны үйл явц юм. “Нийгмийн лиценз”-ийн асуудлыг Моррисон улс төр, эдийн засаг, эрх зүйн зохицуулалтаас ангид авч үзэх, судлах боломжгүй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засаг, эрх зүйн болон

улс төрийн хүлээн зөвшөөрсөн байдал нь нэг нэгнээ орлохгүй бөгөөд эдгээр нь харилцан хамааралтай оршдог байна.


2.2. Нийгмийн лицензийн онол, үзэл баримтлал

Уул уурхайн салбарын үйл ажиллагаанд нийгмийн лиценз олгох тухай онолын үзэл баримтлалыг судлаачид 1990 оноос хойш хөгжүүлж, уул уурхай эрхлэх асуудал өөрөө нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байх тухай судалгааг Жойс болон Томсон нар анх хийсэн байдаг (Joyce 2000). Тэдний үзэл баримтлалаар “Ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын төсөл батлагдаж, нийгэмд үйл ажиллагаагаа явуулахыг хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзвэл “нийгмийн лиценз олгогдсон байх ёстой” гэж үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, судлаачдын үзэл баримтлалд төрийн зүгээс олгож байгаа уул уурхайн лицензтэй зэрэгцэн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь “нийгмийн лиценз”-ийг иргэдийн зүгээс олж авсан байх шаардлагатай гэж үзсэн байна. Тэд 2008 онд нийгмийн лицензийн онолын үзэл баримтлалыг гурван талд хэмжээсээр тодорхойлжээ (Ian Thomson 2008).

Уг асуудлыг 2011 онд Томсон болон Бутилер нар цааш нь хөгжүүлж “Нийгмийн лицензийг загварчлах ба хэмжих” сэдэвт судалгааны ажлыг хийж, үйл ажиллагаа “нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байх” ёстой дөрвөн талт харилцан хамааралт байдлыг тодорхойлжээ (Robert G. Boutilier 2011). Өөрөөр хэлбэл, судалгааны үзэл баримтлалыг харилцан итгэлцлийн пирамидын загварчлалаар боловсруулсан гэсэн үг юм.

Энэ загварчлалын дагуу тэд уурхайн үйл ажиллагааны оролцогч талуудын дунд санал асуулга явуулж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх асуудлыг анх тоон хэмжээсээр хэмжих оролдлого хийжээ. Эхний хувилбар нь судалгаанд оролцогчдоос 24 асуулт бүхий асуулга анкетаар тухайн уул уурхайн үйл ажиллагаатай иргэд санал нийлж байгаа эсэхийг Гутман шкалын 5 баллын хэмжээсээр үнэлүүлж, шинжилгээний үр дүнг бататгах үүднээс ярилцлагын арга ашигласан байна. Гэсэн хэдий ч судалгааны үр дүнд “нийгмийн лиценз”-ийг хэмжих зорилго, таамаглалтай нь нийцээгүй байдаг. Учир нь ярилцлагын арга нь Гутманы шкалын шаардлагыг бүрдүүлээгүй байсантай холбоотой гэж үзэн тайлбарлажээ. Түүнээс гадна факторын шинжилгээний дөрвөн хүчин зүйлийг гаргаж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх асуудлыг дөрвөн түвшинд харьцуулсан. Иймээс асуулгыг боловсронгуй болгохын тулд психометрийг шинжлэх стандарт аргуудыг ашигласан байна. Австрали, Боливи, Мексик улсад хийсэн тэдний судалгааны үр дүнд тэд асуулгыг илүү нарийвчлалтай боловсронгуй болгожээ. Асуулгын сүүлийн хувилбарыг Боливи дахь уурхайд ашиглахдаа 15 асуулттайгаар 5 баллын хэмжээсийг хэрэглэсэн байна. Боливийн нүүлгэн шилжүүлэгдсэн орон нутгийн оршин суугчидтай тэдний амьдралын уналт, өсөлтийн талаар 15 жилийн турш уйгагүй ярилцлага хийсний үр дүнд дараах дөрвөн түвшинг тодорхойлсон байна (Зураг 2).

Зураг 2. Нийгмийн лицензийн “пирамид”-ын загвар



Эх сурвалж: (Ian Tomson, Robert G. Boutilier 2011)

“Нийгмийн лиценз”-ийн пирамидын дөрвөн хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлж, тайлбарласан байдаг. Үүнд:

- **Сэтгэл ижилсэх түвшин (Psychological Identification):** Олон нийт уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжид маш их итгэдэг бөгөөд өөрсдийгөө аж ахуйн нэгжийн ололт амжилтад тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа гэж итгэдэг. Энэ түвшинд оролцогч талууд шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг сурталчилдаг.
- **Зөвшөөрөл олгох түвшин (Approval):** Уул уурхайн эрхлэгч аж ахуйн нэгж нь хууль ёсны эрх болон харилцан итгэлцэл хоёрыг бий болгож чадсан байх бөгөөд түүний дараа олон нийт аж ахуйн нэгжийг хүлээн зөвшөөрөх асуудал.
- **Хүлээн зөвшөөрөх түвшин (Acceptance):** Олон нийт уул уурхай эрхлэгч аж ахуйн зүгээс юу хэлэхийг сонсч, тэдний зүгээс тавих саналыг харгалзаж үзэх хэлбэр юм. Хэрэв тэд өөрсдийн үнэлэмжээр уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжид итгэж болохуйц гэж үзвэл төслийг эхлүүлэхийг хүлээн зөвшөөрөх асуудал.
- **Түтгэлзэх/Хураах түвшин (Withheld/Withdrawn):** Нийгмийн лицензийг түтгэлзүүлэх түвшин нь харилцан итгэлцэлгүй болсон муу хувилбар. Энэ нь иргэдийн зүгээс гомдол гаргах, хаалт тавих, тухайн газар нутагт болон уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжид эсвэл бүхэл бүтэн салбарын

үйл ажиллагааны эсрэг олон нийтийн арга хэмжээ авах асуудлаар илэрдэг.

Судалгааны харьцуулсан үр дүнгээр “нийгмийн лиценз олгох” асуудал нь тухайн уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжид тулгардаг нийгэм-улс төрийн эрсдлийн түвшинтэй урвуу хамааралтай асуудал байна. “Нийгмийн лиценз” олгох онолын загварчлалд нь дөрвөн түвшин, гурван заагийн нөхцөлтэй загварчлалыг түлхүү ашиглаж байна. Эдгээр нь хууль ёсны байдал, харилцан итгэлцэл, итгэл үнэмшлийн норматив шалгуураар авч үзэн холбогдох үзүүлэлтүүдийг боловсруулах боломжийг олгодог байна.

Зураг 3. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих хэмжүүр



Эх сурвалж: (Ian Thomson, Joyce Susan 2008)¹

Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх асуудлыг хэмжих практик хэрэглээний гурван арга зүйг тодорхойлсон бөгөөд тэдгээрийг шууд бус ба шууд хэмжилтийн техник гэж хоёр хувааж болдог байна.

Шууд бус хэмжилт нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хурдан хэдий ч харьцангуй өнгөц хэмжих хэмжүүр юм. Судлаачид эдгээр хоёр аргыг янз бүрийн үзүүлэлт дээр үндэслэн амжилттай ашиглаж ирсэн байна.

- **Физик үзүүлэлтүүд:** Үүнийг доорх хүснэгтэд заасны дагуу нийгэм дэх сэтгэл хөдлөлийн илэрхийлэл гэж ойлгож болох физик үйлдлээр

¹ Тайлбар: Энэхүү пирамид загварын хамгийн дээд түвшин болох “хамтран өмчлөх” нь 2010 онд “Psychological identification буюу сэтгэл ижилсэх” гэсэн нэршлээр өөрчлөгдсөн болно.



илэрхийлдэг. Физик үзүүлэлтийг ашиглах нь аж ахуйн нэгжийн тайлан, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тодорхойлолт дээр үндэслэн хурдан үнэлгээ хийх, зайнаас хийх боломжийг олгодог. Гэхдээ энэ өгсөн мэдээллийн чанар, нэг талыг барьсан, дутуу дулимаг байх боломжтой. Үйл ажиллагааны эсэргүйцлийн жагсаал, цуглаан, хориглолт зэрэг биечлэсэн үйл ажиллагаа нь олон нийтийн санаа бодлын жинхэнэ илэрхийлэл биш байх талтай. Ийм учраас энэ аргачлал нь жинхэнэ үзүүлэлт гэхээсээ илүү шинж тэмдгүүд дээр суурилсан анхан шатны нөхцөл байдлын үнэлгээ юм. Энэ хэмжүүр нь найдвартай байдал дээр дутагдалтай байдаг.

- **Аман үзүүлэлт:** Аман үзүүлэлтийн арга зүйг тухайн судлаач олон нийтийн дунд орж, аж ахуйн нэгж эсвэл төслийг иргэд хэрхэн дүрсэлж байгааг анхааралтай сонсдог ажиглалтын арга юм. Түлхүүр үг, хэллэгийг тэмдэглэж, хэр уялдаатай эсэхийг шинжлэх замаар асуудлыг тодруулдаг. Энэхүү аргыг маш болгоомжтой хэрэгжүүлснээр олон нийтийн дундах үзэл бодлын зөрүү, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын чанарыг хэмжих, нийгэмд хамаатай асуудлууд гэх зэрэг нарийн зүйлүүдийг илрүүлэх боломжтой байдаг.

Зураг 4. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын түвшин ба индикатор

НИЙГМИЙН ЛИЦЕНЗИЙН ТҮВШИН	ШИНЖ ТЭМДЭГ /ҮЗҮҮЛЭЛТҮҮД
ТҮТГЭЛЗЭХ/ХУРААХ	Хаалт, хориг, хүчирхийлэл, хорлон сүйтгэх ажиллагаа, хууль эрх зүйн бэрхшээлүүд
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ	Урт хугацааны үргэлжилсэн асуудлууд, заналхийлэл, хөндлөнгийн ТББ-уудыг байлцуулах, хяналт тавих
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ	Аж ахуйн нэгжийг сайн хөрш гэж үзэх, хамтын ажиллагааны ололт амжилтаар бахархах
СЭТГЭЛ ИЖИЛСЭХ	Улс төрийн дэмжлэг, төслийг хамтран удирдах, шүүмжлэлийн эсрэг нэгдэх

Эх сурвалж: (Ian Thomson, Joyce Susan 2008)

Шууд хэмжилтийн арга зүйг нийгмийн сэтгэл судлаачид анхлан боловсруулсан. Энэ аргачлалыг ашиглан нийгмийн түвшний ойлголтыг нарийвчлан судлах, үйл ажиллагааг нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх дөрвөн түвшинтэй харьцуулан дүгнэх боломжтой. Шууд хэмжилтийн арга нь нийгмийн

лицензийг зөвшөөрсөн байгаа эсэхийг илүү нарийн хэмжихийн зэрэгцээ нийгмийн харилцаанд талуудын эерэг ба сөрөг мэдээллийг дэлгэрэнгүй авах давуу талтай.

Судлаач Томсон болон Бутилер нар уул уурхайн асуудалд олон нийттэй харилцах харилцаанаас илүүтэй оролцогч талуудын харилцааг авч үзэхийг чухалчилдаг (Ian Tomson, Robert G. Boutilier 2011). Учир нь уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лиценз /Social Licence to Operate (SLO)/ гэх ойлголтын хүрээнд хамгийн чухал нь оролцогч талуудын (stakeholders) санаа бодол, ойлголтын зөрүүг (gap among views) нэгтгэх асуудал байдаг гэдэгт бусад судлаачид санал нэгтэй байдаг (Komnitsas 2020). Уул уурхайн эерэг, сөрөг нөлөөллийн талаар нэгдсэн ойлголт байдаггүйгээс улбаалан оролцогч талуудын ойлголтууд зөрүүтэй байх боломжтой юм.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой байдлыг хангах, нийгмийн харилцаанд хурцадмал байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, оролцогч талуудын харилцан итгэлцлийг бий болгох зорилгоор аж ахуйн нэгжүүд нь нийгмийн хариуцлагын стратегийг /Corporate Social Responsibility (CSR)/ боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ утгаараа “нийгмийн лиценз” олж авах загварчлалд эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал хангагдаж байж бусад хүчин зүйлс хангагдах боломжтой гэж үздэг байна. “Нийгмийн лиценз”-ийн суурь зарчмыг хэрэгжүүлэхэд тухайн бүс, орон нутгийн төрийн захиргааны нөлөөлөл чухал гэдгийг онцолдог. “Нийгмийн лиценз”-ийг олж авах аргачлал нь тухайн бүсийн нутгийн газар зүйн байдлаас шалтгаалан өөр өөр байх боломжтой. Оролцогч талуудын харилцааг судлаачид дараах байдлаар дүрсэлжээ (Зураг 5).

Зураг 5. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лицензийн оролцогч талуудын харилцаа




Эх сурвалж: Konstantinos Komnitsas, Social License to Operate in Mining: Present Views and Future Trends, Ghana, 2020.

“Нийгмийн лиценз”-ийг олж авах асуудлыг оролцогч талууд ямар түвшинд ойлгох ёстой вэ гэдэг дээр санал зөрөлдөж болно гэж судлаачид онцолдог. Учир нь уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх асуудлыг үндэсний хэмжээнд эсвэл бүс, орон нутгийн түвшинд харгалзан үзэх ёстой аж. “Нийгмийн лиценз” нь өөрөө нийгмийн өргөн хүрээтэй асуудал тул шууд бус хэмжилт болон аман үзүүлэлтийг зэрэгцүүлж судалгаанд ашиглахыг тэд зөвлөдөг. Өөрөөр хэлбэл, уул уурхайн бүс, орон нутгийн иргэд болон олон нийтийн хооронд саналын болон ойлголтын зөрүү байх бүрэн боломжтой юм.

2008 оны сүүлээр Боливи улсын Сан Кристобал хотод баригдсан уурхайд онолын үзэл баримтлал, арга зүйг туршиж үзэх боломж гаржээ. Тэд өөрсийн боловсруулсан 4 түвшний үзэл баримтлалыг Боливи дахь уул уурхайн оролцогч талуудтай хийсэн судалгаагаар баталгаажуулахыг оролдсон ч нийгмийн лицензийг хэмжих зорилго бүхий таамаглал батлагдаагүй байдаг. Үүний дараа 2011 онд асуулгыг дахин шинэчилж 15 асуулттай байхаар боловсруулан, судалгаанд оролцогчдоос санал нийлж буй байдлыг нь 5 онооны шкалыг ашиглаж факторын шинжилгээ хийсэн байдаг. Судалгааны үр дүнд нийгмийн лицензийн 3 түвшний 4 хүчин зүйлийг тодорхойлсон (Зураг 6).

Зураг 6. Нийгмийн лицензийн пирамид загварыг тодорхойлогч хүчин зүйлс



Эх сурвалж: (Ian Tomson 2011)

Нийгмийн лицензийн түвшин бүрт оролцогч талуудын харьцааг тодорхойлох боломжтой юм:

- Нэгдүгээрт, эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал (*Economic legitimacy*) буюу үндэсний болон бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн ач тус хүртэнэ гэж иргэд үзэж байгаа эсэх (төсөл/аж ахуйн нэгж нь үр ашгаа өгдөг гэсэн ойлголт)
- Хоёрдугаарт, нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал (*Socio-political legitimacy*) буюу үндэсний болон бүсийн нутгийн хэмжээнд амьдралын сайн сайхан байдалд уул уурхайн үйл ажиллагаа хувь нэмрээ оруулж байна гэж иргэд үзэж байгаа эсэх (төсөл/аж ахуйн нэгж нь нийгэмд гүйцэтгэх үүргээ биелүүлдэг оролцогч талуудад шударга ханддаг гэсэн ойлголт)
- Гуравдугаарт, харилцан итгэлцэл (*Interactional trust*) буюу хамтран ажилласнаар иргэдэд итгэл төрүүлж байгаа эсэх (харилцан итгэлцэл гэдэг нь аж ахуйн нэгжийн удирдлага нь үндэсний, бүс нутгийн иргэдийг сонсдог, харилцан яриа хэлэлцээрт ордог гэсэн ойлголт)
- Дөрөвдүгээрт, институциональ итгэл (*Institutionalized trust*) буюу уул уурхайн үйл ажиллагааг эрхлэгч болон орон нутаг, улсын хэмжээний хамтын ажиллагааны харилцаа иргэдэд итгэл төрүүлж байгаа эсэх



(төсөл/аж ахуйн нэгж болон оролцогч талуудын харилцаа бие биенийхээ ашиг сонирхлыг тогтвортой хадгалдаг гэсэн ойлголт) зэрэг дөрвөн хүчин зүйлсийн хүрээнд итгэлцэл бий болсон нөхцөлд “нийгмийн лиценз” олгогдох боломжтой ажээ.

Энэхүү пирамидын загварчлалын талаар хэд хэдэн ажиглалт хийж болдог. Нэгдүгээрт, хамтын ажиллагааны харилцан итгэлцэл доороос дээш чиглэвэл хүчин зүйлүүд нь богино хугацаанд оролцогч талуудын шаардлагыг хангах, урт хугацаандаа институциональ итгэлцэлийн шаардлагыг хангах боломжтой. Харин зүүнээс баруун чиглэлтэй байвал нийгэм-улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал нь харилцан итгэлцэл гэхээсээ илүү соёлын харилцаанд суурилдаг байна. Томсон, Бутилер нар аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй оролцогч талуудтай ярилцахыг илүүд үзжээ.

Онолын үзэл баримтлалыг цааш хөгжүүлэгчдийн нэг бол судлаач Л.Блак юм. Тэр энэ пирамидын загварчлалыг ашиглан 5000 орчим оролцогчтой 60 төслийн үйл ажиллагааг хэмжих оролдлого хийжээ. Тэрээр 2013 оны бүтээлдээ *“Үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лиценз нь төр засгаас олгодог тусгай зөвшөөрөл (лиценз), баримт бичигтэй адилгүй. Энэ нь үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж эсвэл төслүүд тууштай, итгэлтэй зан (байдлаар) оролцогч талуудтайгаа харилцах замаар олж авдаг, нийгэмд хууль ёсны байр суурь эзэлдэг гэсэн нийгмийн ойлголт, хүлээн зөвшөөрлийн хэлбэр”* юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн лиценз гэдэг нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, төслийг бүс нутгийн иргэд болон бусад оролцогч талууд хүлээн зөвшөөрч, зөвшөөрөл олгох түвшин юм. Түүнийг олж авахад хэцүү, алдахад амархан” байдаг гэдгийг онцолсон (Black, The Social License to Operate 2013). Л.Блак нийгмийн лицензийн пирамид загварыг ашиглан дараах 4 стратегийг тодорхойлсон байдаг (Зураг 7).

Зураг 7. Үйл ажиллагаа эрхлэн явуулах нийгмийн лицензийн 4 бүрэлдэхүүн хэсэг



Эх сурвалж: (Black, The Social License to Operate 2013)

- **Хууль ёсны ашиг тус (Legitimate benefits):** Хууль ёсны ашиг тус гэдэг нь оролцогч талуудад хууль ёсны ашиг тусыг өгөх, түүнийг харуулах хэрэгтэй гэсэн ойлголт. Ихэнх аж ахуйн нэгжүүдийн хувьд хууль ёсны ашиг тус нь тухайн бүс нутагт шинэ ажлын байр бий болгох, бүс нутгийнханд дэмжлэг үзүүлэх зэргээр илэрдэг. Ашиг тус гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт. Тухайлбал, орон нутгийн иргэдээс худалдан авалт хийх, бүс нутагт стратегийн хөрөнгө оруулалт хийх, боловсрол, эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, олон нийтийн чадавх бэхжүүлэх санаачлага, хүрээлэн буй орчин, соёл, спортын байгууллагуудын оролцоо зэргийг дэмжих багтана. Хууль ёсны ашиг тусыг олж авах стратеги нь нийгмийн лицензийг хүлээн зөвшөөрөх түвшинд хүрэхэд тусалдаг. Хэрэв ашиг тус дуусч, эсвэл ашиг сонирхлын талуудын хүлээлт өөрчлөгдсөн тохиолдолд нийгмийн лиценз цуцлагддаг. Нийгмийн лицензийг тогтвортой байлгах нөхцөл нь тухайн аж ахуйн нэгж оролцогч талуудын харилцаанд нийгмийн капитал (social capital)-ыг бий болгох шаардлагатай. Тухайн аж ахуйн нэгж нь бүс нутгийн иргэдэд хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн гэрээ (social contract)-г бий болгоход хэрэгтэй. Ашиг тусын стратеги, нийгмийн гэрээ 2-ыг хамтад нь хэрэгжүүлэх нь аж ахуйн нэгжийн хувьд ач холбогдолтой юм.
- **Нийгмийн капитал (Social capital):** Нийгмийн капитал гэдэг нь итгэлцэл, харилцан ойлголцол, нийтлэг үнэт зүйлс болон зан төлөв



зэрэг нь аж ахуйн нэгж болон тэдний оролцогч талууд, олон нийтийг холбож хамтран ажиллах боломжийг олгодог. Нийгмийн капитал нь оролцогч талуудын идэвхтэй харилцаа, олон нийтийн тогтвортой хөгжлөөс хамаарна. Тухайлбал, амлалтаа биелүүлэх, анхааралтай сонсох замаар олж авдаг. Судлаач Адлер, Квон нар нийгмийн капиталыг сайн санаанаас үүдэлтэй, ашиг тусаа өгөх боломжтой хөрөнгө гэж тодорхойлсон байдаг. Энэ нь хүмүүс хамтын зорилгодоо хүрэхийн тулд бие биетэйгээ хамтран ажиллах чадвар юм.

- **Нийгмийн гэрээ (Social contract):** Нийгмийн гэрээ гэдэг нь аж ахуйн нэгж/төсөл нийгэмд ажиллах эрхээ олж авах, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх шууд бус гэрээний хэлбэр юм. Нийгмийн гэрээ нь тухайн аж ахуйн нэгж үйл ажиллагааг урт хугацаанд хууль ёсны болгох үндэс болдог. Оролцогч талууд тухайн аж ахуйн нэгжийн бүс нутагт авчирч буй зардал, үр ашгийн шударга хуваарилалтын талаарх үнэлэмжийг бий болгодог. Нийгмийн лицензийн гол түлхүүр нь нийгмийн гэрээний элементүүдийг бий болгох, бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх санаачилгыг гаргах эсвэл орон нутгийн сайн сайхны төлөө хувь нэмэр оруулах явдал юм. Ингэснээр аж ахуйн нэгжүүд бүс нутгийн талаар илүү мэдэж, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хүндэтгэж байгаагаа харуулах боломжтой болдог. Оролцогч талуудын оролцоо гэдэг нь нийгмийн лицензийн нийгмийн гэрээний элементийг олж авах үйл явц юм. Олон талт оролцоо нь аж ахуйн нэгжүүд болон бүс нутгийн тогтвортой ирээдүйд юу чухал болохыг олон нийттэй хуваалцах, нийгмийн капиталыг бий болгоход тусалдаг.
- **Байгууллага хоорондын итгэлцэл (Inter-organisational trust):** Байгууллага хоорондын итгэлцэл нь тодорхой стратеги биш бөгөөд өмнөх гурван стратегийг сайн хэрэгжүүлсний үр дүнд бий болдог зүйл. Аж ахуйн нэгж нь оролцогч талуудтай харилцаагаа үр дүнтэй өрнүүлж, бүс нутгийн тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь институциональ итгэлцлийг бий болгож, сэтгэл ижилсэх хэлбэр юм. Ингэснээр олон нийтэд уг төслийг өмчилж буй мэдрэмж төрдөг. Энэ үед оролцогч талууд тухайн аж ахуйн нэгжтэй харилцаж байсан түүхээ үндэслэн чин сэтгэлээсээ санаа зовж, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг харгалзан олон нийтийг оролцуулахыг зорьдог. Удаан хугацааны турш үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоох шаардлагатай болсон үед оролцогч талууд нийгмийн лицензэд санаа зовж эхэлдэг. Цаашилбал, янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан нийгмийн лицензийн эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрийг бүрдүүлэхийн тулд өгөгдсөн тактикуудыг ашиглах боломжтой.

2.3. Нийгмийн лицензийг хэмжих судалгааны арга зүй

Дэлхийн хөгжиж буй ихэнх улс орнуудын хувьд орон нутгийн оролцогч талууд хариуцлагатай уул уурхай эрхлэх асуудлыг ашиглан уул уурхайн компанитай засгийн газрын түвшинд гэрээ байгуулахаас илүүтэй нийгмийн гэрээ хэлэлцээр хийхийг хичээж ажилладаг байна. 2014 онд баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт (2014-2025) энэ агуулгыг “Тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, бүс нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд бүс нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх; Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулан” ажиллах гэж тусгажээ. Судлаач Я.Томсон, Р.Бутилер нар энэхүү загварыг ашиглан уул уурхайн төслүүдийн үйл ажиллагааны тухай тайлбарлахдаа компаниуд нь нийгэм-улс төрийн болон хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдлаас илүү бүс нутагт харилцан итгэлцэлд хүрэх нь илүү хялбар байдаг хандлагыг дурдсан байна. Тухайлбал, компаниуд янз бүрийн оролцогч талуудтай харилцах харилцаагаа сайжруулах санаачилга гаргадаг тул тэднийг хяналтандаа байлгах боломжтой. Харин “нийгэм-улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” нь компанийн шууд хяналтанд байх нь илүү төвөгтэй асуудал гэж үзсэн байна (Зураг 8).

Зураг 8. Оролцогч талуудын харилцааг тодорхойлогч нийгмийн лицензийн гурван түвшний дөрвөн хүчин зүйл



Эх сурвалж: [Ian Tomson 2011]

Эдгээр түвшин бүрт оролцогч талуудын харьцааг тодорхойлдог. Тухайлбал:

1. *Institutional trust* – Институциональ итгэлцэл
2. *Interactional trust* – Харилцан итгэлцэл
3. *Economic legitimacy* – Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. *Socio-political legitimacy* – Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал

Тус загварын талаар тэд хэд хэдэн ажиглалт хийж болохыг дурдсан байдаг. Нэгдүгээрт, доороос дээшээ чиглэсэн бол хүчин зүйлүүд нь богино хугацааны оролцогч талуудын шаардлагыг хангах, урт хугацаанд байгууллагын түвшний шаардлагыг хангахтай тохирдог. Харин зүүнээс баруун тийш чиглэсэн бол “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “харилцан итгэлцэл” гэхээсээ илүү нийгмийн соёлд суурилсан ойлголттой тулгардаг гэжээ. Нийгэм-улс төрийн болон хууль ёсны байдлын үндэс нь шудрага ёс болох бөгөөд үүнийг үнэлэхийн тулд өөр өөр соёлын шалгуур үзүүлэлтийг ашигладаг болохыг онцолсон (Зураг 9).

Зураг 9. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын түвшин тус бүрт оролцогч талуудын эзлэх хувиар хүчин зүйлсийн харилцааны өөрчлөлтийг харуулсан загвар



Эх сурвалж: (Ian Tomson 2011)²

² Тайлбар: Зураг 6.

- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын түвшин тус бүрт олгох оролцогч талуудын хувь хэмжээг дөрвөн хүчин зүйл нь тус бүртээ өндөр эсвэл бага оноогоор хэрхэн өөрчлөгдөх боломжтойг жишээгээр харуулав. Зүүн захын загвар дээр төсөл/компанийг зөвхөн эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангасан гэж үздэг. Өөрөөр хэлбэл, компани нь оролцогч талуудтай эдийн засгийн харилцаа хийхээс өөр зүйлийг санал болгодоогүй гэсэн үг юм. Иймээс олгож болох нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх цар хүрээг диагональ шугамын дагуу бүсэд хязгаарлаж болно. Энэ нь ихэвчлэн улаан, шаргал бүс байх бөгөөд өндөр эрсдэлтэй болохыг харуулж түтгэлзэх/хураах хоёрын хооронд сулардаг байна.
- Дунд байгаа загвар төслийг “нийгэм улс төрийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн” гэх хэдий ч “институцэд итгэх итгэл” гүй гэж үздэг байна. Эдгээр хоёр хүчин зүйлтэй тохирч буй пирамидын талбайн доод оноог илэрхийлэх зорилгоор гаргаж авсан болно.
- Баруун захын загвар илүү ногоон өнгөтэй байдаг. Энэ нь “нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдал” нь шар бүсийн эргэн тойронд хэлбэлзэх магадлалтайг харуулдаг. Хамгийн сайн үед ногоон бүсийн хязгаарт хүрч, хамгийн муу үед улаан бүсэд татагдах магадлалтай. Энэ загвар дээр оролцогч талууд “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “харилцан итгэлцэл” бүхий үйл ажиллагаа гэж үздэг байна. Зөвхөн “институцэд итгэх итгэлцэл” нь дутаж байгааг харж болно. Энэ тохиолдолд ногоон бүс бараг хоёр дахин нэмэгддэг. Учир нь үйл ажиллагаа хүлээн зөвшөөрөгдсөн байх магадлал өндөр гэж үзсэн байна.

Тэдний энэ судалгаанаас гарсан үр дүнг (modified cumulative scale)-тэй 85 хувь тохирч байна гэж “Үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лиценз: Өөр нэрээр хууль ёсны болох уу” гэсэн сэдэвт судалгаанд бичсэн байна (L. L. Joel Gehman 2017). Тухайлбал, “институциональ итгэлцэл” дээр өндөр оноо авсан оролцогч талууд бусад хүчин зүйл дээр өндөр оноотой байх боломжтой юм. Эсэргээрээ “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” ба “харилцан итгэлцэл” дээр бага оноо авсан оролцогч талууд хэзээ ч “институциональ итгэлцэл” дээр өндөр оноо авах боломжгүй гэж Томсон, Бутилер нар үзсэн байна. Мөн тэд “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын хүчин зүйлээс доогуур оноотой оролцогч талууд бусад хүчин зүйлс дээр хэзээ ч өндөр оноо авах боломжгүй гэж үзсэн байна.

Л.Блак 2013 онд пирамидын загварыг 14 асуулттай асуулгыг ашиглаж хэмжих оролдлого хийсэн байна (Black, The social license to operate: Your management framework for complex times. 2013). Тэрээр Ликертийн 1-5 онооны шкалыг 14 асуулттайгаар боловсруулсан байдаг. Энэхүү шкалаар нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх байдлын оноог тооцоолохын тулд оролцогчдын тоогоор хариулсан хариултын дундажийг тооцоолдог. Хэрэв олон оролцогчидтой бол тэднийг ангилж болно. Тухайлбал, бүс нутгийн, засгийн газрын, байгаль орчин хамгааллын идэвхтнүүд гэх зэргээр ангилах боломжтой. Блак энэхүү ангилал доторх онооны хазайлтыг шалгаж үзэхийг зөвлөсөн байдаг. Учир нь онооны өндөр хэлбэлзэл оролцогч талуудын хоорондын стратегийг боловсруулах асуудал дээр чухал ялгааг нууж байх боломжтой гэж үзсэн. Түүний боловсруулсан “нийгмийн лиценз”-ийг хэмжих энэхүү арга аргачлалыг 5000 орчим оролцогчидтой 60 төсөлд ашиглаж үзсэн байна.

Хүснэгт 1. Нийгмийн лицензийн онооны хүрээ

Бүрэн итгэл	4.5-4.99
Зөвшөөрөл олгохуйц	4.0-4.49
Өндөр хүлээн зөвшөөрөлт	3.5-3.99
Дунд зэргийн хүлээн зөвшөөрөлт	2.5-3.49
Хүлээн зөвшөөрөлт бага	2.5-3.00
Түтгэлзэх/Хураах	1.0-2.49

Эх сурвалж: (Black, The social license to operate: Your management framework for complex times. 2013)

Р.Бутилерын 2017 онд хийсэн “Дэд бүтцийн болон олборлох салбарын төслүүд дэхүйлажиллагааэрхлэхнийгмийнлицензийгхэмжихнь” судалгаандааасуултыг ойлгох цаг хугацаа, соёлтой харьцуулж болохуйц элементүүдэд анхаарч юуг хэмжих ёстойг тайлбарласан байдаг (Boutilier 2017). Тэрээр судалгаандаа олон тооны асуулт ашиглаж эхэлсэн ч явцын дунд багасгасан. Тэрээр дөрвөн хүчин зүйлийг ашиглан 15 асуулттай асуулга боловсруулжээ. Түүний онцолж байгаагаар сөрөг үгтэй асуулт нь оролцогч талуудыг төөрөгдүүлдэг тул тэд асуултын утганаас эсрэг хариу өгдөг болохыг олж тогтоосон байна. Судалгааны ярилцлагын үед тоон хариулт болон тэдний жинхэнэ мэдрэмжийн хоорондох тохиролыг тодруулах амаргүй байжээ. Судалгааны үр дүнд “түтгэлзэх/хураах” –тай холбоотой асуултын өгөгдлийг хялбархан тодорхойлсон ч “зөвшөөрөл олгох”-оос хүлээн зөвшөөрөхийг хооронд нь ялгахад хэцүү байсан тул 2011 онд илүү их өгөгдөл цуглуулж дахин факторын шинжилгээ хийсэн байдаг. Тухайлбал, дөрвөн хүчин зүйлийг ашиглан бусад хүчин зүйлүүдэд хэт их ачаалал өгөлгүйгээр хүчин зүйл тус бүрийг ялгаатайгаар хэмжсэн 15 асуултыг сонгон боловсруулжээ. Гэсэн хэдий ч 15 асуултаас хоёр хувьсагчийн хүч нь сул ($n = 562$, өөрийн утга: 7.313, Cronbach’s Alpha: 0.943) байсан тул үлдсэн 13 асуултан дээр факторын шинжилгээ хийсэн байна. Шинжилгээгээр хоёр асуултын хариулт ижил төстэй үг хэллэгтэй байсан. Тухайлбал, “[Компани] бидний ашиг сонирхолд санаа зовж байна” (бета ачаалал 0.659), “[Компани] бидний ашиг сонирхлыг харгалзан үздэг” (бета ачаалал 0.794) байв. Эдгээрээс хамгийн бага ачаалалтай “[Компани] бидний ашиг сонирхолд санаа зовж байна” гэсэн асуултын хариултыг хассан байна. Үлдсэн 12 асуултаар нийгмийн лицензийг хэмжихэд өөрчлөхгүйгээр ашиглаж болно гэж тэмдэглэжээ (хүснэгт 2).

Хүснэгт 2. Нийгмийн лицензийг хэмжих 12 асуултын загварчлал

Д/д	Асуултын нэр
1	Компани нь бидэнд хамаатай асуудлаар мэдээлэл хуваалцдаг
2	Компани нь бүс нутгийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулдаг
3	Компани нь бидний ашиг сонирхлыг харгалзан үздэг
4	Компани нь бидний хийх зүйлийг хүндэтгэдэг
5	Бид компанитай харилцах харилцаандаа сэтгэл хангалуун байдаг
6	Компани хүн болгонд айдас төрүүлдэг
7	Компанитай харилцах харилцаанаас бид хожиж чадна
8	Компани биднийг сонсдог
9	Компанийн ашиг тус болох эсэх
10	Компанид илүү их нөлөөлдөг хүмүүст тэд тусламж үзүүлдэг
11	Компани нь бидэнд хамаатай асуудлаар шийдвэр гаргадаг
12	Компани нь бидэнтэй адил алсын хараатай

Эх сурвалж: (Boutilier 2017)

Энэхүү судалгааны аргачлал нь бусад салбарыг өргөжүүлэх, уламжлалт болон цахим хэвлэл мэдээллийн хэрэгслээр текстийг үнэлэх, нэг санаачилгаас нөгөө санаачилгын үр дүнд бий болох “нийгмийн лиценз”-ийн түвшинг загварчлах сайн эхлэл болж чадсан байна. Орхигдуулж болохгүй чухал ойлголт бол оролцогч талууд компанитай харилцах харилцааныхаа талаарх ойлголтоо тайлбарлахдаа уул уурхайн үйл ажиллагааны төслийн талаар ямар сэтгэгдэлтэй байгааг нэгтгэн дүгнэх явдал юм гэж судлаачид онцолсон байна.

Энэхүү загварчлалыг Монгол улсад 2018 онд Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) анх ашигласан байна. Өмнөговь аймгийн иргэдийн “Говийн оюу” хөгжлийг дэмжих сан болон уул уурхайн компаниудад итгэх итгэлийг тодорхойлох зорилгоор ашиглажээ. Тэд судалгааны арга зүйгээ иргэдийн суурь итгэлцлийн түвшингээр тодорхойлохыг зорьсон бөгөөд “Говийн оюу” хөгжлийг дэмжих санд итгэх итгэлийг гурван түвшинд авч үзсэн байна.

- Нэгдүгээрт, амьдралын чанарын субъектив ерөнхий үнэлгээгээр;
- Хоёрдугаарт, тухайлсан итгэлцлийн үнэлгээгээр, тухайлбал нийгмийн бүлгийн итгэлцлийн үнэлгээ;
- Гуравдугаарт, Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд итгэх итгэлийн үнэлгээгээр хэмжсэн байна.

Үйл ажиллагааны оролцогч талууд нь Өмнөговь аймгийн иргэд, хөгжлийн санг санхүүжүүлэгч, үйл ажиллагаанд оролцогч тал гэсэн гурван талт итгэлцэл өндөр байх ёстой гэсэн үзэл баримтлалаар судалгааны арга зүйг дэвшүүлсэн байдаг.

2.4. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал

1990 онд Монгол Улс нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн эрчим хүч эрдэс баялгийн салбар зах зээлийн зарчмаар өөрийнхөө хөгжлийг тодорхойлох болж, төрийн болон хувийн өмчийн хэлбэр зэрэгцэн оршин эрэлт нийлүүлэлтийг зохицуулж эхэлсэн. Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай хууль, Алтны тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль зэргийг боловсруулахад ихээхэн анхааржээ. Тухайлбал, “Алт-1”, “Газрын тос” хөтөлбөрийг Монгол улсын анхны ерөнхийлөгч П.Очирбатын санаачилгаар (Засгийн газрын 304 тогтоол 1991), боловсруулж, батлуулан хэрэгжүүлсэн байна. Тухайн үед Монгол улсын хэрэгжүүлж байгаа төрийн эрдэс баялгийн бодлогыг дэлхий дахинд хүргэх, улмаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогын хүрээнд нефтийн орд газруудыг хайх, ашиглах талаар АНУ, Австралийн компаниудтай бүтээгдэхүүн хуваах анхны гэрээнүүд байгуулж, Японы засгийн газрын тусламжтайгаар зарим орд газрын судалгааг эхлүүлэх, говийн аймгуудын зураглалын ажлуудыг хийлгэж, ураны орд газрыг хамтран ашиглах асуудлаар ОХУ, АНУ-тай монгол аж ахуйн нэгжүүдтэй хоёрлосон, гуравласан гэрээг байгуулж эхэлсэн байна.

Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд нээлттэй өрсөлдөх зарчмыг нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалт хийж эхэлсэн байна.

2000 оноос хойш уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй хурдацтай өсч, уул уурхайн салбарын эдийн засгийн өсөлтөд эзлэх хувь хэмжээ эрс нэмэгдсэн байна (УУБҮБ-ын үнэлгээний цуврал тайлан 2017). Өмнө нь зөвхөн зэсийн баяжмалын экспорт тэргүүлж байсан бол энэ үеэс нүүрс, төмрийн хүдэр зэрэг эрдэс баялгийн олборлолт, баяжуулалт хурдацтай өсч эхэлжээ. 2009 оны 9 дүгээр сарын 6-нд Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ хийгдсэн нь Монгол Улсын хувьд уул уурхайн салбарт өрнөсөн томоохон үйл явдал байлаа. Энэ цаг мөчтөй зэрэгцэн Таван толгойн орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах анхны алхмууд хийгдэж эхэлсэн байдаг. Өнөөдөр Эрдэнэс таван толгой, Энержи Ресурс ХХК нь манай улсын нүүрсний хамгийн том экспортлогч болоод байна (Industrie- und Handelsbericht in Bayern, Aussenwirtschaft Austria April 2019). Уул уурхайн салбарт 2019 оны байдлаар 56 мянга гаруй ажилчид ажиллаж дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 72 хувь, экспортын бүтээгдэхүүний 90 хувийг үйлдвэрлэж Монгол улсын эдийн засагт тэргүүлэх байр суурийг эзлэж байна. 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 10,402.0 тэрбум төгрөг болсон байна. Үүнээс эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2,673.3 тэрбум төгрөг байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулбал Уул уурхайн салбараас 2,522.9 тэрбум төгрөг буюу 24.3 хувь, Газрын тосны салбараас 102.8 тэрбум төгрөг буюу 1.0 хувь, Тусгай зөвшөөрлийн төлбөр 32.7 тэрбум төгрөг буюу 0.3 хувь, бусад орлого 14.9 тэрбум төгрөг буюу 0.1 хувь байна (Үндэсний статистикийн хороо 2020).

Уул уурхайн салбарын оролцогч талуудыг анхдагч болон хоёрдогч гэж ангилах ба үйл ажиллагаа явуулах бүс нутгийн хүн амыг “анхдагч” оролцогч тал буюу “үндсэн” оролцогч тал гэж нэрлэдэг байна. Зарим тохиолдолд оролцогч тал нь бүс нутгийн бус байх тал бий. Эдгээр оролцогч талуудын харилцааг зохицуулахаар Монгол улсын Ашигт малтмалын тухай хуульд дараах заалтуудыг оруулсан байна. Тухайлбал, 42.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. 42.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно. Өөрөөр хэлбэл, оролцогч талуудын хоёрдогч тал болох үйл ажиллагаа эрхлэгчдийг тодорхойлсон байна. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал

авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж заажээ (18.4 дүгээр заалт). Өөрөөр хэлбэл, уул уурхай эрхлэгчид 42.1-р заалтаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон нутгийн иргэдийн зөвшөөрлийг авах ёстой гэсэн үг юм. Энэ утгаараа нутгийн иргэд, “анхдагч оролцогч тал”-ыг орон нутгийн засаг дарга төлөөлөх, ашиг сонирхлыг нь хамгаалах үүрэгтэй болж байна.

Оролцогч талын үр дүнтэй оролцоог хангах асуудал нь зарим тохиолдолд салбарын үйл ажиллагаанд зөрчил, зөрчилдөөн үүсгэх нөхцөл болохын зэрэгцээ нийгэмд талцал үүсгэдэг байна. Тухайлбал, хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны үе шатууд удаашрах нь хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагч нарт ихээхэн зардал төвөг учруулахын хажуугаар нийгэмд үл ойлголцол үүсгэх үндэс нь болдог ажээ. Иймд аль болох салбарын үйл ажиллагаанд талуудын оролцоог хангах, оролцогч талуудтай зөвлөлдөх замаар уул уурхайн салбарын «үйл ажиллагааг нийгэмд буюу Монгол улсын хэмжээнд болон орон нутагт хүлээн зөвшөөрүүлэх,» нь зайлшгүй урьдчилсан нөхцөл болдог. Монгол улсын хувьд уул уурхайн компани нь ашигт малтмалын ямар нэгэн үйл ажиллагаа явуулахын тулд хэд хэдэн албан ёсны тусгай зөвшөөрөл эзэмших олж авсан байх ёстой бөгөөд эхлээд хайгуулын, дараа нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авна (Монгол улс дахь Азийн Сан 2007). Энэ утгаар УИХ-аас 2014 онд баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт (2014-2025) тодорхой заасан байдаг. Тодруулбал “Тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх; Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах” гэж заасан байна. Энэ агуулгыг 2020 онд баталсан “Бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулиар илүү тодорхой болгож өгсөн байна. Тухайлбал, тус хуулийн 5.1.13 болон 5.2.13 заалтаар “*бүх талын оролцоог хангасан байх зарчим*”-ыг мөрдөнө гэжээ.

Талуудын оролцоог хангах тухай асуудлаар төрийн байгууллага дээр иргэний танхим нээлттэй ажиллах, үйл ажиллагааны хүрээнд шилэн данс хөтлөх, орон нутгийн хөгжлийн сангийн тайлан, мэдээллийг ил тод байдлаар нийгэм, олон нийтэд хүргэх үүрэгтэй ажиллаж байна. Эдгээр нь сайн засаглалын гол хэмжүүрүүд бөгөөд оролцогч талуудыг үнэн зөв, мэдээлэлтэй байлгах, тэдний идэвхтэй оролцоотойгоор асуудлыг шийдэхэд чиглэх юм. Зарим нөхцөлд энэ онолын арга зүй практик амьдралд хэрэгжих явцдаа асуудалтай тулгарах нь олонтой. Үндэсний Хөгжлийн Газрын төсөл

хөтөлбөрийн тайланд тусгагдсанаар нийт 46 орчим томоохон хэмжээний, 100 гаран дунд болон жижиг хэмжээний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон эхлүүлэхээр дурьдсан байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 “нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллах”, 42.2 “нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулах” болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн 18.4 “орон нутгийн захиргааны байгууллага, үйл ажиллагаа эрхлэх орон нутгийн иргэдээс санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулах” заалтууд нь нийгмийн лицензийн үндсэн агуулга болно. Ашигт малтмалын тухай хууль, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн агуулгын зөрчил нь уул уурхай эрхлэн явуулж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Энэхүү агуулгын зөрчил нь нэг талаас иргэдэд өрөөсгөл ойлголт төрүүлж, бүс нутгийн иргэдийн уул уурхайн үйл ажиллагаанд итгэх итгэлцлийг бууруулж байна. Энэ нь онол арга зүйн түвшинд дэвшүүлж тавьсан Томсон, Блэк нарын онолын үзэл баримтлал болох шууд (анхдагч) оролцогч талын (бүс нутгийн иргэд) ашиг сонирхлыг хамгаалах нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна. Нөгөө талаас эдгээр хуулийн заалтын хүрээнд нутгийн захиргааны байгууллага бүс орон нутгийн ашиг сонирхлыг төлөөлж байгаа нь уул уурхайн үйл ажиллагааг олон нийт эсэргүүцэх үндсэн шалтгаан болж байна. Дээрх нөхцөл байдлын улмаас “Монгол” хүний уул уурхайд хандах хандлагыг тодруулж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах хэрэгцээ, шаардлага үүсч байна.

2.5. Судалгааны үзэл баримтлал

“Уул уурхайн салбарын үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдал буюу нийгмийн лиценз”-ийг дараах онол, үзэл баримтлалаар тодорхойлов (Зураг 10).

Зураг 10. Судалгааны үзэл баримтлалын хүрээ



Эх сурвалж: Судалгааны багийн тодорхойлсноор.

Түтгэлзэх/хураах: Нийгмийн лицензийн хамгийн доод түвшин нь үйл ажиллагаанд олгосон зөвшөөрлийг “түтгэлзэх/хураах” асуудал. Нийгмийн лицензээ алдах нь нийгэм улс төрийн эрсдэлийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх түвшнөөс, зөвшөөрөл олгох түвшинд хүрсэн ч итгэл алдрах нөхцөлд уул уурхайн үйл ажиллагааг түтгэлзэх болон хураах түвшин хүртэл буурч болдог гэж судлаачид үздэг (Ian Tomson, Robert G. Boutilier 2011).

Легитим зааг нь түвшин хоорондыг зааглах бөгөөд эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдалтай нягт уялдаатай. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн харилцан хамааралт байдал нь үйл ажиллагааг түр хугацаанд зөвшөөрөх тухай ойлголт юм.

Хүлээн зөвшөөрөх: “Хүлээн зөвшөөрөх” гэдэг нь нийгмийн лицензийн нийтлэг түвшинг харуулж буй хамгийн чухал хэсэг юм. Хэрэв уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаараа нийгэмд харилцан итгэлцлийг бий болгож чадвал нийгмийн лиценз “зөвшөөрөл олгох” түвшин хүртлээ өсдөг (Ian Tomson, Robert G. Boutilier 2011).

Итгэл хүлээлгэх зааг нь хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөл олгох хоёр түвшний дундыг заагладаг. Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал болон харилцан итгэлцэлтэй шууд уяалдаатай. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн ашигтай байдлаас үүдэлтэй богино хугацааны итгэл хүлээлгэх тухай асуудал юм.

Итгэлцлийн зааг нь зөвшөөрөл олгох ба сэтгэл ижилсэх түвшинг заагладаг. Энэ зааг нь институционал итгэлцэлтэй уялдадаг. Өөрөөр хэлбэл,

уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх тухай асуудал юм.

Сэтгэл ижилсэх нь нийгмийн лицензийн хувьд урт хугацааны туршид харилцан итгэлцэл бүрдсэн нөхцөлд нийгэм-улс төрийн эрсдэл бага байдаг. Энэ нөхцөлд “сэтгэл ижилсэх” түвшин хүртэл нэмэгдэж болдог (Ian Tomson, Robert G. Boutilier 2011). Сэтгэл ижилсэх түвшний үед уул уурхайн үйл ажиллагаа болон бүс нутгийн иргэдийн амьдралын хэв маяг ижилсдэг.

Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан итгэлцэл хоёр нэг түвшинд байрладаг. Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын үндэс нь шударга ёс. Үүнийг үнэлэхийн тулд өөр өөр соёлын шалгуур үзүүлэлтийг ашиглах хэрэгцээ шаардлага бий болдог (Ian Tomson 2011). Шударга ёсны соёлын шалгуур үзүүлэлтүүд нь итгэл үнэмшилтэй нягт уялддаг. Өөрөөр хэлбэл, шударга ёсны хэмжүүр нь тухайн улс үндэстний онцлог шинжийг илэрхийлдэг байна (Зураг 11).

Зураг 11. Нийгмийн лицензийг бүрдүүлэгч хүчин зүйлс




Эх сурвалж: (Black, The social license to operate: Your management framework for complex times. 2013)

Нийгмийн лиценз нь хүмүүсийн итгэл үнэмшил, бодол санаа, мэдрэмж дээр үндэслэдэг ойлголт юм. Эдгээр нь шинэ мэдээлэл олж авахад эсвэл нийгмийн нөлөөлөл бий болоход өөрчлөгдөж байдаг динамик ойлголт (Black 2013). Хувь хүний хандлага нь хүний танин мэдэхүй, мэдрэмжийг баталгаажуулах бодол санааг хамруулан авч үздэг. Үүнд мэдлэг, итгэл үнэмшил, мэдрэмж болон түүнтэй холбоотой дурсамж, дүр зураг багтдаг (Thomas Gilovich 2013). Тиймээс хандлага нь аливаа нэгэн зүйлд дуртай эсвэл дургүй байдлыг илэрхийлнэ. Мөн хандлага нь тодорхой зан үйлтэй уялддаг (M. Fishbein 1975). Тухайлбал зан үйл, уламжлалт ёс, шашин шүтлэг зэрэг орно. Иймд судлаачид нийгмийн сэтгэл зүйг хэмжихэд хандлагын асуултуудыг өргөн ашигладаг.

Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг судалгааны “түлхүүр” хүчин зүйл хэмээн тодорхойлсон болно. 2018 оны “Говийн оюу” хөгжлийг дэмжих санд итгэх итгэлцлийн судалгааг Бутилерын 15 асуултын дагуу хийсэн байдаг.

Уг судалгаагаар нийгмийн харилцан итгэлцлийн суурь нь Монголчуудын хувьд хамгийн түрүүнд гэр бүл, дараа нь хамаатан садан, найз нөхөддөө итгэдэг болох нь тогтоогдсон. Өөрөөр хэлбэл, нийгмийн итгэлцлийн асуудал нэг талаасаа хувь хүний хөгжлийн асуудал, нөгөө талаас нийгмийн хөгжлийн түвшинг илэрхийлэх хэмжүүр юм. Энэ утгаараа уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг эсэргүүцэх шалтгаан нь итгэлцлийн асуудлаас илүүтэй хандлагын хүчин зүйл байх магадлалтай. Тиймээс “Нийгмийн лиценз” олгох түвшин хоорондын шилжилтэд монгол хүний уул уурхайн үйл ажиллагаанд хандах хандлагыг тодруулах зорилгоор үзэл баримтлалаа дараах байдлаар тодорхойлов (Зураг 12).

Зураг 12. Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлсон зураглал



Эх сурвалж: Судалгааны үзэл баримтлалын хүрээ

Монгол хүний уул уурхайд хандах хандлага, түүний талаарх мэдлэг, итгэл үнэмшилтэй холбоотой таван хүчин зүйлийг хувьсагчаар хэмжихийг зорьсон. Учир нь “нийгмийн лиценз”-ийн түвшин хоорондын шилжилтийн



заг нь өөрөө тухайн улс үндэстний онцлог шинж, зан үйлтэй холбоотой болохыг онцолж байна. Тухайлбал, нийгмийн лицензийг судалсан олон улсын судлаачдын санал шүүмжээр Бутилер, Томсон нарын 2011 онд хийсэн судалгааны үр дүн таамаглалтай нь зөрж байсан шалтгаан нь “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” болон “харилцан итгэлцэл” хоёрын хоорондох нөлөөлөх хүчин зүйлийг олоогүйд байсан. Тэд зөвхөн “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” болон “харилцан итгэлцэл” хоёрын хооронд “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” бий гэж үзсэн нь учир дутагдалтай байжээ. Мөн Роберт Бутилерын 2017 онд хийсэн *“Дэд бүтцийн болон олборлох салбарын төслүүд дэхь үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лицензийг хэмжих нь”* судалгаандаа асуултыг бөглөх цаг хугацаа, улс үндэстний соёл болон хувь хүний хандлага гурав нь итгэлцэлд нөлөөлж байгааг онцолсон (Boutilier 2017).

Энэхүү судалгааны үзэл баримтлалаар “институциональ итгэлцэл” гэдгийг “Төрийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх иргэдийн итгэл үнэмшил” гэж ойлгож болно. Цаашид энэ агуулгаар тайлбарлана. Учир нь төр эрх зүйн зохицуулалтаар 1992 оноос эхлэн хайгуулын болон олборлолтын лицензийг уул уурхай эрхлэгч хувийн хэвшилд олгож эхэлсэн. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад тухайн бүс нутгийн төрийн захиргааны байгууллага болон иргэдийн эсэргүүцэл, дарамт шахалт гэдэг зүйлстэй байнга тулгарч байна. Энэ төрлийн эсэргүүцэл, дарамт шахалттай тулгарч байгаа шалтгаан нь ихэвчлэн бүс нутгийн иргэдийн мэдлэг, боловсрол, уул уурхайн тухай ойлголт, хамтран ажиллах туршлага дутмаг байгаатай холбоотой. Ийм учир шалтгааныг тодруулах зорилгоор хандлагыг нэгдүгээрт, хувь хүний мэдлэгээр хэмжих, иргэдийн уул уурхайн талаарх мэдлэгтэй эсэхийг өөрсдийн үнэлгээгээр нь хэмжихдээ “аминч үзэл” болон “оролцоо”-г тодорхойлогч хүчин зүйл байхаар боловсруулсан. Харин уул уурхайн үйл ажиллагаатай харилцах хувь хүний харилцааг хоёрдугаарт, итгэл үнэмшлийг хэмжихдээ хувь хүний нийгмийн соёлд суурилсан “байгаль орчноо хамгаалах сэдэл” болон нийгмийн харилцаанд хандах хандлагыг бусдад итгэх “итгэлцэл”-ээр хэмжихийг зорив. Уг үзэл баримтлалыг тайлбарлахын тулд монгол хүний хандлагыг хэмжих таван хүчин зүйлийг 1-7 баллын үнэлгээтэй байхаар боловсруулсан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1. Судалгааны төрөл, түүний зорилго

Тус судалгааны зорилго нийгмийн лицензийг тайлбарлахад чиглэнэ. Судалгааны үзэл баримтлалын хүрээ нь олон улсад нийгмийн лицензийг судлахад түлхүү ашигладаг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулах замаар 1. Монгол Улсын уул уурхайн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын баримт цуглуулах, баримт бичгүүдэд шинжилгээ хийнэ. Баримт бичгийн шинжилгээг хийхдээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах арга зүйг ашиглана. 2. Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдлын түвшинг үнэлэх зорилгоор судлаач Томсон болон Бутилер нарын 2011 онд ашигласан судалгааны анкетын асуулгыг монгол хэлнээ хөрвүүлэн ашиглах бөгөөд агуулгын алдааг хянах үүднээс давхар ярилцлагын аргыг хэрэглэнэ. 3. Ярилцлагын аргыг хэрэглэхдээ өгөгдсөн удирдамжийн дагуу Томсон болон Бутилер нарын арга зүйг үндэслэн шууд хэмжилтийн аргыг ашиглана. Энэ нь уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх асуудлыг Монгол Улсын хувьд илүү нарийн хэмжих боломжийг олгох бөгөөд нийгмийн харилцааны зөрөг ба сөрөг талуудын мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж өгөх давуу талтай.

3.2. Судалгааны эх олонлог, түүврийг тодорхойлох

Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдалд хийх судалгаанд Монгол улсын нийт хүн амын сонгуулийн насны 2,157,011 иргэнийг эх олонлог болгон хамруулан авч үзнэ. Ингэхдээ орон зай, өнөөгийн цаг үеийн байдалтай уялдуулан түүвэр олонлогийг хоёр хэсгээс бүрдүүлнэ. Нэгдүгээрт нийслэл хотын 9 дүүргийн сонгуулийн насны 941,517 иргэнийг хотын иргэдийн төлөөлөл, хоёрдугаарт Ашигт малтмал газрын тосны газрын санал болгож буй Дорнод аймгийн Хэрлэн, Баяндун, Дашбалбар, Матад сумын сонгуулийн насны иргэдийг хөдөө орон нутгийн төлөөлөл болгон хамруулан түүврийн хэмжээг тодорхойлсон. Энэ нь судалгааны 95%-ийн итгэх түвшинтэй 2.5 хувийн хэлбэлзэлтэй түүврийн хэмжээнд найдвартай байдлын түвшинг хангасан болно. Хоёр хэсэг судалгааны өгөгдлийг анкетаар болон ярилцлагын аргыг хослуулан хийж судалгааны үр дүнг факторын болон хамаарлын шинжилгээгээр хүчин зүйлсийг харьцуулан дүн шинжилгээ хийж гүйцэтгэв.

Хүснэгт 3. Нийслэл хотын 9 дүүргийн сонгуулийн насны иргэдийн тоо

Дүүргийн нэрс	Хорооны тоо	Сонгуулийн насны иргэдийн тоо
Багануур	4	19,321
Багахангай	2	2,686
Баянгол	20	147,205
Баянзүрх	20	224,709
Налайх	7	24,006
Сонгино хайрхан	21	214,345
Сүхбаатар	16	92,552
Хан-Уул	14	109,747
Чингэлтэй	18	106,946
Нийт	121	941,517

Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар, 2017 он (газар 2017).

Хүснэгт 4. Дорнод аймгийн 4 сум, дүүргийн сонгуулийн насны иргэдийн тоо

Сум/Дүүрэг	СД	Сонгуулийн насны иргэдийн тоо
Хэрлэн	04	2067
Баяндун	19	2259
Дашбалбар	22	2219
Матад	01	28833
Нийт	-	35,378

Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо (хороо, Тайлан 2020)

Зураг 13. Монгол улсын сонгуулийн насны хүн амын тоогоор түүврийн хэмжээг тодорхойлсон байдал

Determine Sample Size

Confidence Level: 95% 99%

Confidence Interval:

Population:

Sample size needed:

Эх сурвалж: <https://www.surveysystem.com/sscalc.htm>

3.3. Хувьсагч, түүний хэмжигдэхүүнийг тодорхойлох

Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдалд хийх судалгааны “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “харилцан итгэлцэл”, “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “институциональ итгэлцэл” гэсэн дөрвөн хүчин зүйл бүхий загварт дүйцүүлэн нэгтгэнэ.

Хүснэгт 5. Нийгмийн лицензийг хэмжих концептуализаци/операционализаци

Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал	Харилцан итгэлцэл	Нийгэм-Улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал	Институцэд итгэх итгэл	Бид уул уурхайн тогтолцоотой, цаашид ашиг хүртэж чадна
				Бид уул уурхайн компаниудтай харилцаагаа өргөжүүлж болно
				Бид өөрсдийн гол зорилгодоо хүрэхийн тулд уул уурхайн компаниудтай хамтын ажиллагаатай байх хэрэгтэй
				Уул уурхайн компаниудтай юу гэж ярилцана бидний хамтын ажиллагаанд хэрэгждэг
				Бид уул уурхайн компаниудтай бий болгосон харилцаандаа маш сэтгэл хангалуун байдаг
				Уул уурхайн компаниудтай байх нь бидэнд ашигтай
				Биднийг уул уурхайн компаниуд сонсдог
				Ур хугацаандаа уул уурхайн компаниуд нв бүс нутгийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулна
				Уул уурхайн компаниуд хүн бүрт шударга ханддаг
				Уул уурхайн компаниуд хүн бүрийн хийж буй зүйлийг хүндэтгэдэг
				Уул уурхайн компаниуд болон манай байгууллага бүс нутгийн ирээдүйд адил алсын хараатай
				Уул уурхайн нь сөргөөр нөлөөлж байгаа хүмүүст илүү дэмжлэг үзүүлдэг
				Уул уурхайн компаниуд гаргасан шийдвэрээ бидэнд мэдэгддэг
				Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхлыг харгалзан үздэг



				Уул уурхайн компаниуд бидэндтэй холбоотой мэдээллийг хуваалцдаг
				Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхлын талаар санаа тавьдаг

Олон улсад туршигдсан дээрх асуултуудыг судалгааны онцлог байдалтай уялдуулан утгыг өөрчлөхгүйгээр засварлаж анкетээр бөглүүлэх ба Ликертийн шкалын 1-7 баллын хэмжээсээр боловсруулж, шинжилгээний үр дүнг бататгах зорилгоор ярилцлага хийнэ.

Хүснэгт 6. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих асуултууд

Д/д	Асуултын нэр	Хэмжих шкал (1-7 балл)
Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал		
1	Монгол улс уурхайн компанитай харилцах харилцаагаа өргөжүүлж чадна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
2	Монгол улс хамгийн чухал зорилгодоо хүрэхийн тулд уурхайн компанитай хамтын ажиллагаатай байх шаардлагатай гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
Харилцан итгэлцэл		
3	Уурхайн компаниуд Монгол улстай хамтын ажиллагааныхаа хүрээнд хийх зүйлээ л хийдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
4	Монгол улс уурхайн компаниудтай харилцах харилцаандаа сэтгэл хангалуун байдаг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
5	Уурхайн компаниуд байгаа нь Монгол улсад ашигтай гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
6	Уурхайн компаниуд нь Монгол улсын иргэдийг сонсдог гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал		
7	Урт хугацаандаа Монгол улсын хувьд уул уурхайн компаниуд бүс нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулна гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна

8	Уурхайн компаниуд нь Монгол улсын иргэн бүрт шударга ханддаг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
9	Уурхайн компани олон нийтийн хийж буй зүйлсэд хүндэтгэлтэй ханддаг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
10	Уурхайн компаниуд бүс нутгийн ирээдүйн талаар Монгол улсын иргэдтэй адил алсын хараатай гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
Институцэд итгэх итгэл		
11	Уурхайн компаниуд Монгол улсын иргэдтэй гаргасан шийдвэрээ хуваалцдаг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
12	Уурхайн компаниуд Монгол улсын ашиг сонирхлыг харгалзан үздэг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
13	Уурхайн компаниуд Монгол улсын ашиг сонирхолд санаа тавьдаг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
14	Уурхайн компаниуд Монгол улстай холбоотой мэдээллийг нээлттэй хуваалцдаг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
15	Уурхайн компаниуд нь тэдний үйл ажиллагааны улмаас хохирч буй иргэдэд илүү их дэмжлэг үзүүлдэг гэж бодож байна	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна

Судалгааны үзэл баримтлалын хүрээтэй уялдуулан монгол хүний уул уурхайд хандах хандлага гэсэн ойлголтыг “уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт”, “аминч үзэл”, “оролцоо”, “байгаль хамгаалах сэдэл”, “бусдад итгэх итгэл” гэсэн таван хүчин зүйлээр хувьсагч үүсгэн Ликертийн шкалаар 1-7 баллын хэмжээсээр хэмжилт хийнэ.

Энэ судалгааны өгөгдсөн нөхцөлд тохируулан өмнөх судалгааны зарим үр дүнг ашиглан нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээний хуваарийг дараах байдлаар тодорхойлон авч үзэж байна.

Хүснэгт 7. Монгол улс дахь нийгмийн лицензийн онооны хүрээ

Бүрэн итгэл	6.5-6.99
Зөвшөөрөл олгохуйц	6.0-6.49
Өндөр хүлээн зөвшөөрөлт	5.5-5.99
Дунд зэргийн хүлээн зөвшөөрөлт	4.5-5.49
Хүлээн зөвшөөрөлт бага	3.0-4.49
Түтгэлзэх/Хураах	1.0-2.99

Эх сурвалж: Судлаачид тооцоолсон

Сайн сайхан байдлын болон нийгмийн лицензийн судалгааны тархалтыг шинжлэн үзвэл монгол хүний өөрийн санаа бодлыг шууд эрс эсэргүүцэж илэрхийлдэггүй за яахав гэдэг хандлага нь үнэлгээний дундажийг өндөр болгоход нөлөөлдөг нь ажиглагдсан учир түтгэлзэх онооны суурь хувиар өндөр байна.

Хүснэгт 8. Монгол хүний уул уурхайд хандлагыг хэмжих асуултууд

Д/д	Асуултын нэр	Хэмжих шкал (1-7 балл)
1	Уул уурхайн талаар би сайн мэднэ	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
2	Уул уурхайн талаар монголчууд сайн мэдлэгтэй	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
3	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь надад ашигтай	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
4	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь иргэн бүрт ашигтай	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
5	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд надаас асуух ёстой	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
6	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд Дорнод аймгийн бүх иргэдээс асуух ёстой	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
7	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд Монгол улсын иргэн бүрээс асуух ёстой	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
8	Би байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг хүн	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
9	Монголчууд байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг ард түмэн	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
10	Би өөртөө итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
11	Би гэр бүлдээ итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна

12	Би төрөл садандаа итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
13	Би найз нөхөддөө итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
14	Би хамт олондоо итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
15	Би танихгүй хүнд итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна
16	Би гадны улс үндэстэнд итгэдэг	1. Санал огт нийлэхгүй байна 7. Санал маш их нийлж байна

3.4. Хүчинтэй ба найдвартай байдал

3.4.1. Фактор шинжилгээ

Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдалд хийх судалгааг хоёр бүлэг бүхий нийт 31 асуулт боловсруулж нэмэлтээр оролцогчдын хувийн мэдээллийг асуусан болно. Хоёр бүлэг асуултуудын дотоод нийцтэй байдлыг мөн дэд асуултууд хэр оновчтой, найдвартай байгааг шалгахын тулд олон удаагийн оролдлогоор шалгаж үзсэн болно. Эхний удаад нийт 32 оролцогчоос авсан өгөгдлийн шинжилгээнд “монгол хүний уул уурхайд хандах хандлага”-ыг хэмжих асуултуудын найдвартай байдал хангалттай хэмжээнд хүрээгүйн улмаас дахин шинэчилж, өөрчилсөн болно. Шинэчилсэн хувилбараар боловсруулсан 16 анкетын асуулгын хүчинтэй ба дотоод нийцтэй байдлын шинжүүрийг шалгахад 6 хүчин зүйлд хуваагдаж, үүнээс 9 дэх асуулт буюу “монголчууд байгаль орчноо хамгаалж, дээдлэн хүндэлдэг ард түмэн” хасагдаж 8 дах асуулт болох “Би байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг хүн” дангаараа “байгаль хамгаалах сэдэл”-ийн хүчин зүйлийг төлөөлж чадахгүйн улмаас хасагдсан болно.

Хүснэгт 9. Хүчинтэй ба дотоод нийцтэй байдлын шинжүүрийн үр дүн

Д/д	Нэгж хувьсагчид	Фактор 1	Фактор 2	Фактор 3	Фактор 4	Фактор 5	Фактор 6
1	Уул уурхайн талаар би сайн мэднэ						.792
2	Уул уурхайн талаар монголчууд сайн мэдлэгтэй						.850
3	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь надад ашигтай				.911		



4	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь иргэн бүрт ашигтай				.913		
5	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд надаас асуух ёстой		.778				
6	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд бүс нутгийн бүх иргэдээс асуух ёстой		.836				
7	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд Монгол улсын иргэн бүрээс асуух ёстой		.859				
8	Би байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг хүн			.770			
9	Монголчууд байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг ард түмэн						
10	Би өөртөө итгэдэг			.840			
11	Би гэр бүлдээ итгэдэг			.811			
12	Би төрөл садандаа итгэдэг	.819					
13	Би найз нөхөддөө итгэдэг	.874					
14	Би хамт олондоо итгэдэг	.860					
15	Би танихгүй хүнд итгэдэг					.853	
16	Би гадны улс үндэстэнд итгэдэг					.874	

3.4.2. Найдвартай байдлын шинжилгээ

Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг хэмжсэн 6 бүлэг хүчин зүйлийн найвартай байдлыг шалгаж үзэхэд “уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт”-г тандах судалгааны асуултуудын найдвартай байдлын Кронбах Альфа утга 0.569 буюу хангалтгүй гэсэн үзүүлэлттэй байгаагаас хасагдсан болно (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг хэмжих хүчин зүйлсийн найдвартай байдал

	Хүчин зүйлийн нэрс	Кронбах Альфа утга
Фактор 1	Уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт	0.569
Фактор 2	Аминч үзэл	0.842
Фактор 3	Оролцоо	0.797
Фактор 4	Өөртөө итгэх итгэл	0.793
Фактор 5	Бусдад итгэх итгэл	0.870
Фактор 6	Гадны хүнд итгэх итгэл	0.696

Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тандах нийт 12 асуултын найдвартай байдал 0.719 байгаа нь хүлээн зөвшөөрөхүйц байгааг илтгэж байна. Эндээс Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг хүчинтэй ба найдвартай байдлыг шалгуур хангасан 5 хүчин зүйл болох “аминч үзэл”, “оролцоо”, “өөртөө итгэх итгэл”, “бусдад итгэх итгэл”, “гадны хүнд итгэх итгэл” төлөөлж чадахаар байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг хэмжих асуултуудын Кронбах Альфа утга

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standartixed Items	N of Items
0.750	0.772	12

Олон улсад батлагдсан нийгмийн лицензийн 4 бүлэг хүчин зүйлийн найдвартай ба дотоод нийцтэй байдлыг тандан судлаж үзэхэд тус бүр онц, сайн гэсэн утгыг илэрхийлж байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих асуултуудын Кронбах Альфа утга

	Хүчин зүйлийн нэрс	Кронбах Альфа утга
Фактор 1	Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал	0.771
Фактор 2	Харилцан итгэлцэл	0.809
Фактор 3	Нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал	0.860
Фактор 4	Институциональ итгэлцэл	0.890

Нийгмийн лицензийг хэмжих 4 бүлэг хүчин зүйлийн нийт найдвартай байдал 0.932 байгаа нь онц сайн утгыг илэрхийлж байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэмжих асуултуудын Кронбах Альфа утга

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standartixed Items	N of Items
0.932	0.935	15

3.5. Өгөгдөл цуглуулах үйл явц

Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдлыг судлах зорилгын хүрээнд өгөгдлийг хоёр хэсгээс бүрдүүлнэ. Үүнд:

1. Улаанбаатар хотын дүүргийн 1536 иргэнийг хамруулан цахимаар анкетын асуулга авах
2. Дорнод аймгийн Баяндун сумын орон нутгийн иргэдээс санамсаргүй түүврийн аргаар өгөгдөл цуглуулж, шинжилгээ хийнэ. Мөн чанарын судалгааны экспертийн ярилцлага хийж шинжилгээний үр дүнг бататгасан.

Судалгааны анкет асуулга 3 бүлэг асуултаас бүрдэх бөгөөд нийт 37 асуултаас бүрдэнэ. Үүнд:

Q. Шүүлтүүр асуултууд

A. Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлсон асуултууд

B. Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдлыг үнэлэх асуултууд

3.6. Өгөгдөлд шинжилгээ хийх үйл явц

Судалгааг дараах хоёр үе шаттайгаар боловсруулалт хийсэн болно. Үүнд:

- **Анкетийн асуулгын аргаар цуглуулсан өгөдлийг боловсруулах**

Судалгааны нийт өгөгдлийг SPSS 23 тооцооллын программыг ашиглан шинжилсэн болно. Өгөгдлийг шалгахдаа 18-аас доош насны иргэдийн үнэлгээ, бөглөөгүй орхисон, дутуу бөглөсөн, анхааралгүй бөглөсөн зэрэг өгөгдлүүдийг хасах замаар шалгасан. Мөн судалгааны дотоод нийцтэй байдал, найдвартай байдалд тус тус шинжилгээ хийн бататгасан. Мөн “нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” болон “монгол хүний уул уурхайд хандах хандлага”-ыг тандах асуултад факторын шинжилгээ хийж бүлэг тус бүрийн найдвартай ба дотоод нийцтэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тооцож, шалгасан болно.

- **Ярилцлагын аргаар цуглуулсан өгөдлийг боловсруулах**

Судалгааны зорилгоосоо хамааран сонгогдсон Дорнод аймгийн Хэрлэн, Баяндун сумын иргэдээс ярилцлага аргыг ашиглан өгөгдөл цуглуулсан болно. Хэрлэн, Баяндун, сумын иргэд болон аж ахуйн нэгжийн төлөөлөл болох 10 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийхдээ “Монгол


хүний уул уурхайд хандах хандлага"-ыг тодруулах зорилгоор "уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт", "аминч үзэл", "оролцооны хэлбэр", "байгаль хамгаалах сэдэл", "бусдад итгэх итгэл" гэсэн таван хүчин зүйлийг В бүлгийн нийгмийн лицензийг хэмжих асуулгыг бөглөсөн үр дүнг харгалзан ярилцсан. Ингэхдээ орон нутгийн иргэдийн сэтгэл зүйн нөхцөл байдлыг харгалзан нэг үзэл бодолд туйлшрах байдлаас сэргийлэх үүднээс орон нутагт уул уурхай эрхэлж байгаа аж ахуйн нэгж болох гадаадын хөрөнгө оруулалттай Шинь Шинь ХХК болон алт олборлогч Эс Жи Майнинг ХХК-ийн төлөөллүүдтэй экспертийн ярилцлага хийж, үр дүнг бататгасан болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

4.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


Нийгмийн лиценз буюу уул уурхайн салбарын үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдалд хийсэн судалгаанд нийслэл хот, орон нутгаас нийт 1536 иргэн оролцсон шаардлага хангасан 1510 өгөгдөлд боловсруулалт хийсэн болно. Үүнээс 1106 иргэн нийслэл хотоос, 404 иргэн хөдөө, орон нутгийн (Хэрлэн, Баяндун, Дашбалбар, Матад) төлөөлөл байв. Судалгаанд хамрагдсан иргэдийн насны бүлгийн хамгийн өндөр хувийг 30-44 насныхан, үүнээс 55.4 хувийг нийслэл хотын иргэд, 50.0 хувийг орон нутгийн иргэд, 45-64 насныханы 27.3 хувийг хотоос, 30.9 хувийг орон нутгаас, 18-29 насныхан 17.2 хувь хотоос, 15.1 хувь орон нутгаас байгаа бол 65-аас дээш насныхан хамгийн бага буюу 0.1 хувийг хотоос, 4.0 хувийг орон нутгаас тус тус бүрдүүлж байна (Зураг 14).

Зураг 14. Судалгаанд оролцсон нийслэл хот, орон нутгийн иргэдийн хувь, насаар харьцуулсан байдал




Судалгаанд хамрагдсан 1510 иргэний ерөнхий мэдээлийг хүйсийн ялгаатай байдлаар нь авч үзвэл 55 хувийг эмэгтэйчүүд, 45 хувийг эрэгтэйчүүд тус тус бүрдүүлж байна (Зураг 15).

Зураг 15. Судалгаанд оролцсон иргэдийн хүйсийн байдал нийслэл хот, орон нутгаар




Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын иргэдийн боловсролын түвшинг ерөнхий байдлаар нь харьцуулж үзвэл 95.3 хувийг дээд боловсролтой иргэд буюу хамгийн өндөр хувьтай, мэргэжлийн ба техникийн боловсролтой 1.3 хувь, бүрэн дунд боловсролтой 3.2 хувь, бүрэн бус дунд боловсролтой 0.3 хувийг тус тус бүрдүүлж байна (Зураг 16).

Зураг 16. Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн боловсролын түвшин




Судалгаанд хамрагдсан Дорнод аймгийн иргэдийн боловсролын түвшинг ерөнхий байдлаар нь харьцуулж үзвэл дээд боловсролтой иргэд 55.8 хувь буюу хамгийн өндөр хувьтай, харин мэргэжлийн ба техникийн 4.7 хувь, бүрэн дунд боловсролтой 20.8 хувь, бүрэн бус дунд боловсролтой 15.9 хувь, бага боловсролтой 2.5 хувь, боловсролгүй иргэд 0.2 хувийг тус тус бүрдүүлж байна (Зураг 17).

Зураг 17. Судалгаанд оролцсон Дорнод аймгийн иргэдийн боловсролын түвшин




Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд бүтэн цагийн ажилтай 92.6 хувь, хагас цагийн ажилтай 2.4 хувь, ажилгүй иргэд 1.4 хувь, оюутан 1.2 хувь, тэтгэвэт 0.5 хувь, гэртээ хүүхдээ асардаг 1.1 хувь, бусад төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг иргэд 0.9 хувийг тус тус бүрдүүлж байна (Зураг 18).

Зураг 18. Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн ажил эрхлэлтийн байдал



Дорнод аймгаас судалгаанд хамрагдсан иргэдийн 65.8 хувь буюу дийлэнх нь бүтэн цагийн ажилтай иргэд, тэтгэвэрийн насныхан 7.9 хувийг, ажилгүй 7.4 хувийг, гэртээ хүүхдээ асардаг 2.5 хувийг, хагас цагйн ажилтай 2 хувийг, оюутан 1 хувийг эзэлж бусад төрлийн ажил хөдөлмөр эрхэлдэг иргэд 13.4 хувийг тус тус бүрдүүж байна. (Зураг 19).

Зураг 19. Судалгаанд оролцсон Дорнод аймгийн иргэдийн ажил эрхлэлтийн байдал



4.2. Монгол хүний уул уурхайд хандах хандлага

Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хот, Дорнод аймгийн иргэдийн уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч 6 хүчин зүйлсийн дундаж оноог харьцуулж үзэхэд хотын иргэдийн аминч үзэл 4.35, оролцоо 4.88, байгаль хамгаалах сэдэл 6.47, өөртөө итгэх итгэл 6.59, бусдад итгэх итгэл 2.60, гадны хүнд итгэх итгэл 2.68 гэсэн дундаж онооны үзүүлэлттэй байна. Харин хөдөөгийн иргэдийн аминч үзэл 3.86, оролцоо 5.41, байгаль хамгаалах сэдэл 6.26, өөртөө итгэх итгэл 6.35, бусдад итгэх итгэл 5.83, гадны хүнд итгэх итгэл 2.35 гэсэн дундаж онооны үзүүлэлттэй байна (Хүснэгт 14).


Хүснэгт 14. Монгол хүний уул уурхайд хандах хандлагыг тодорхойлох асуултуудын дундаж оноо хот, хөдөөгөөр

Д/д	Асуулт	Хот	Хөдөө
Дундаж утга			
Аминч үзэл			
		4.35	3.86
1	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь надад ашигтай	4.22	3.72
2	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь иргэн бүрт ашигтай	4.48	3.99
Оролцоо		4.88	5.41
3	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд надаас асуух ёстой	4.51	4.94
4	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд Дорнод аймгийн бүх иргэдээс асуух ёстой	5.42	5.72

5	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд Монгол улсын иргэн бүрээс асуух ёстой	4.71	5.56
	Өөртөө итгэх итгэл	6.59	6.35
6	Би өөртөө итгэдэг	6.54	6.33
7	Би гэр бүлдээ итгэдэг	6.65	6.36
	Бусдад итгэх итгэл	2.60	5.83
8	Би төрөл садандаа итгэдэг	5.86	6.04
9	Би найз нөхөддөө итгэдэг	5.71	5.76
10	Би хамт олондоо итгэдэг	5.63	5.69
	Гадны хүнд итгэх итгэл	2.68	2.35
11	Би танихгүй хүнд итгэдэг	2.75	2.53
12	Би гадны улс үндэстэнд итгэдэг	2.62	2.17

Судалгаанд оролцсон Улаанбаатар хот, Дорнод аймгийн иргэдийн уул уурхайд хандах хандлагыг графикаар харьцуулан харуулахад дараах зураглал гарч байна. Хотын иргэдийн аминч үзэл дундажаас дээгүүр байгаа бол хөдөөгийн иргэдийн аминч үзэл дундажаас доогуур үзүүлэлттэй байна. Хот, хөдөөгийн иргэдийн “оролцоо” болон “өөртөө итгэх итгэл” аль аль нь дундажаас дээгүүр үзүүлэлттэй байгаа бол “гадны хүнд итгэх итгэл”-ийн дундаж үзүүлэлт доогуур байна. Харин “бусдад итгэх итгэл”-ийн үзүүлэлт ялгаатай байгаа нь хотын иргэдийн үзүүлэлт дундажаас нэлээд доогуур байгаа бол хөдөөгийн иргэд дундажаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Зураг 20. Монгол хүний уул уурхайд хандах хандлага хот, хөдөөгөөр



Судалгаанд оролцсон хот, хөдөөгийн иргэдийн хандлагын ялгаатай байдал нь “бусдад итгэх итгэл” болон “аминч үзэл” дээр илүү тодорч, бусад үзүүлэлт ялгаа багатай байсан. Тухайлбал, орон нутгийн иргэдийн бусдад итгэх итгэл нь

Улаанбаатар хотын иргэдээс их байсан бол эсэргээрээ хотын иргэдийн аминч үзэл нь орон нутгийн иргэдээс их байгаа нь амьдрах орчноос хамааралтай болохыг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн иргэдийн ахуй нь иргэд хоорондын харилцааны хамааралтай байгаа бол хотын иргэдийн ахуй нь хувь хүний хүчин зүйлтэй холбоотой болох нь тодорч байна.

4.3. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдал

Олон улсын судлаачид Я.Томсон, Р.Бутилер нарын хөгжүүлсэн 15 асуултыг Л.Блакийн хөгжүүлсэн 14 асуулттай арга зүйн хувьд дундаж үнэлгээгээр нь харьцуулан үзвэл ойролцоо үнэлгээтэй байна. Энэ нь олон улсад ашиглагдаж найдвартай байдлыг хангасан асуултууд Монгол улсад мөн найдвартай байдлыг хангаж байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлох асуултуудын дундаж үнэлгээ нийслэл хот, орон нутгаар

Д/д	Асуулт	Хот		Хөдөө	
	Судалгааны арга зүй	Арга 1 ³	Арга 2 ⁴	Арга 1	Арга 2
1	Бид уул уурхайн компанитай харилцах харилцаагаа өргөжүүлж чадна	4.66	4.66	3.99	3.99
2	Бид хамгийн чухал зорилгодоо хүрэхийн тулд уурхайн компанитай хамтын ажиллагаатай байх хэрэгтэй	5.08	5.08	4.67	4.67
3	Уул уурхайн компаниуд бидэнтэй хамтын ажиллагааныхаа хүрээнд хийх зүйлээ л хийдэг	3.8	3.8	3.46	3.46
4	Бид уул уурхайн компаниудтай харилцах харилцаандаа сэтгэл хангалуун байна	2.94	2.94	2.84	2.84
5	Уул уурхайн компаниуд байгаа нь бидэнд ашигтай	4.28	4.28	3.8	3.8
6	Уул уурхайн компаниуд нь биднийг сонсдог	2.73	2.73	2.62	2.62
7	Урт хугацаандаа уул уурхайн компаниуд бүс нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулна гэж бодож байна	4.25	4.25	3.9	3.9
8	Уул уурхайн компаниуд нь бидэнд шударга ханддаг	2.71	2.71	2.53	2.53
9	Уул уурхайн компаниуд нь олон нийтийн хийж буй зүйлсэд хүндэтгэлтэй ханддаг	2.88	2.88	2.89	2.89
10	Уул уурхайн компаниуд бүс нутгийн ирээдүйн талаар бидэнтэй адил алсын хараатай байдаг	3.09	3.09	2.85	2.85
11	Уул уурхайн компаниуд бидэнд хамаатай гаргасан шийдвэрээ хуваалцдаг	2.74	2.74	2.63	2.63

³ Судалгааны арга 1: Судлаач Томсон болон Бутилер нарын боловсруулсан 15 асуулт бүхий судалгааны арга.

⁴ Судалгааны арга 2: Судлаач Блакийн боловсруулсан 14 асуулт бүхий судалгааны арга.




12	Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхлыг харгалзан үздэг	2.7	2.7	2.45	2.45
13	Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхолд санаа тавьдаг	2.53	-	2.45	-
14	Уул уурхайн компаниуд бидэнтэй холбоотой мэдээллийг нээлттэй хуваалцдаг	2.56	2.56	2.54	2.54
15	Уул уурхайн компаниуд нь тэдний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй буй иргэдэд илүү их дэмжлэг үзүүлдэг	3.52	3.52	3.05	3.05
	Нийт	3.36	3.42	3.11	3.15

Тайлбар: Судлаач Л.Блак, Я.Томсон болон Р.Бутилер нарын боловсруулсан 15 асуултын 13 дахь асуулт буюу “Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхолд санаа тавьдаг” гэсэн асуултыг ашиглаагүйгээрээ ялгаатай юм.

Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээ Улаанбаатар хотод 4.87, Дорнод аймагт 4.33 буюу хотын иргэдийн хувьд эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөр байна. Харилцан итгэлцлийн дундаж үнэлгээ Улаанбаатар хотод 4.66, Дорнод аймагт 3.18 буюу хотын иргэдийн харилцан итгэлцэл хөдөөгөөс харьцангуй өндөр байна. Нийгэм, улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээ хотод 3.23, хөдөө 3.04 буюу нийслэлд өндөр байна. Институциональ итгэлцэлийн дундаж үнэлгээ нийслэлд 2.81, орон нутагт 2.62 буюу нийслэлийн иргэд орон нутгийн иргэдээс илүү итгэл хүлээлгэж байна. Эдгээр үнэлгээний ялгаатай тал нь Комнитасасын үзэл баримтлалын дагуу орон нутгийн иргэд нь нийслэлийн иргэдтэй харьцуулахад эдийн засаг, нийгэм, байгаль орчны хувьд шууд хамааралтай байгаа нь тодорч байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа бүс, орон нутгийн иргэд нь нийгмийн лиценз олгох анхдагч оролцогч тал болох нь судалгааны үр дүнгээр харагдлаа. Нийгмийн лиценз олгох асуудлыг түдгэлзэх магадлал орон нутгийн иргэдийн хувьд илүү өндөр байна.


Зураг 21. Судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын хүчин зүйлсийг үнэлсэн байдлын харьцуулалт нийслэл хот, орон нутгаар (судалгааны арга 1)



Тайлбар: Судалгааны арга 1. Зураг 21-д нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг Томсон болон Бутилер нарын 15 асуулт бүхий пирамидын загвар дээр үндэслэн гаргасан үнэлгээний харьцуулалт болно.


Улаанбаатар хотын иргэдийн хувьд Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдалд хийсэн судалгааны үр дүнд “нийгэм, улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “институциональ итгэлцэл” хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь нийгмийн лицензийн зөвшөөрөл олгох түвшин бага, сэтгэл ижилсэх түвшинд хүрэх магадлал бага байгааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, оролцогч талуудын ялгаатай ашиг сонирхлыг илтгэж байна. Энэ нь Томсон болон Бутилер нарын сануулж байсантай нэгэн адил оролцогч талуудын харилцааг ярилцлагын аргаар тодруулах ёстойг баталж өглөө. Үлдсэн хэсэг болох “харилцан итгэлцэл” болон “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байгаа нь нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдалтай байгаа хэдий ч хэлбэлзэх магадлалтай байгааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, нийгмийн лиценз улаан бүсээс ногоон бүс хооронд хэлбэлзэж, хамгийн сайн үед ногоон бүсийн хязгаарт хүрэх боловч хамгийн муу үед улаан бүсийн хязгаарт хүрч цуцлагдах эрсдэлтэй байна гэсэн үг юм (Зураг 22).

Зураг 22. Улаанбаатар хотын иргэдийн нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээгээр тооцоолсон пирамидын зураглал (судалгааны арга 1)



Уул уурхайн үйл ажиллагааг нийгэм хүлээн зөвшөөрөх байдалд хийсэн судалгааны үр дүнд Дорнод аймагт зөвхөн “эдийн засгийн хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал”-тай байгаа бөгөөд бусад гурван хүчин зүйл нь дутагдалтай байна. Энэ нь тухайн бүс, орон нутагт уул уурхай эрхэлж буй аж ахуй нэгжүүд үндсэндээ санхүүгийн гүйлгээ хийхээс өөр бусад зүйлийг санал болгодоггүй, иргэд болон оролцогч талуудын зүгээс зөвшөөрлийн түвшинг олгох нь ховор ба сэтгэл ижилсэн түвшинд хүрэх магадлал тун бага байна. Тиймээс голчлон улаан, шар өнгийн бүсэд хүлээн зөвшөөрөгдөх эсвэл хураагдах эрсдэлтэй нөхцөлд байгааг харуулж байна. Судалгаанд оролцсон хот, хөдөөгийн иргэдийн хандлагын ялгаа нь харилцан итгэлцэл байгаа хэдий ч судлаач Комницасын загварчиллаар онцолсон шинж болох анхдагч, хоёрдогч оролцогч талуудын ялгаа тодорч байна.

Зураг 23. Дорнод аймгийн иргэдийн нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээгээр тооцоолсон пирамидын зураглал (судалгааны арга 1)



Эндээс үзэхэд судлаач Томсон, Бутилер нарын “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” ба “харилцан итгэлцэл” дээр бага оноо авсан тохиолдолд хэзээ ч “институциональ итгэлцэл” дээр оноо авах боломжгүй гэдгийг баталж байна. Эсрэгээрээ “институциональ итгэлцэл” дээр өндөр оноо авсан тохиолдолд бусад хүчин зүйл дээр өндөр оноотой байх боломжтой гэж үзсэн байдаг (L. L. Joel Gehman 2017).

Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг Л.Блакийн арга зүй (судалгааны арга 2)-ээр авч үзвэл хотод 3.42, хөдөө 3.15 гэсэн дундаж онооны үзүүлэлт нь хүлээн зөвшөөрөлт бага гэсэн онооны хүрээг харуулж байна. Энэ нь Томсон, Бутилер нарын пирамидын загвараар тайлбарлавал эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай байгааг илэрхийлнэ. Улаанбаатар хотын иргэдийн нийгмийн лицензийн дээрх үзүүлэлтийг Дорнод аймагтай харьцуулахад өндөр байгаа нь хотын иргэд уул уурхайн үйл ажиллагаанаас шууд эдийн засаг, нийгмийн хамаарал багатай байгааг илтгэж байна.

Хүснэгт 16. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын онооны хүрээ (судалгааны арга 2)

Онооны хүрээ	Үнэлгээний хуваарь	Хот	Хөдөө
Бүрэн итгэл	6.5-6.99		
Зөвшөөрөл олгохуйц	6.0-6.49		
Өндөр хүлээн зөвшөөрөлт	5.5-5.99		
Дунд зэргийн хүлээн зөвшөөрөлт	4.5-5.49		
Хүлээн зөвшөөрөлт бага	3.0-4.49	3.42	3.15
Түтгэлзэх/Хураах	1.0-2.99		

Тайлбар: Судлаач Л.Блакийн аргаар боловсруулсан үр дүн

Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдал түтгэлзэх түвшинг давсан төдий байгаа нь энэ салбарын талаар судалгаанд оролцогчид улсаас зөвшөөрсөн учир хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй гэсэн ойлголттой байгааг илэрхийлж байна. Үүний шалтгаан нь Монгол улс төрийн байгуулалтын хувьд нэгдмэл тогтолцоотой бөгөөд зөвхөн засаг захиргаа, нэгжийн зохион байгуулалтаар төрийн үйл ажиллагаа эрхлэдэг тул бүс, орон нутгийн ашиг сонирхол уул уурхайн үйл ажиллагаанд тусгалаа олохгүй үлдэх магадлал төсвийн нэгдсэн тогтолцоонд илэрдэг. Учир нь уул уурхайн үйл ажиллагааны эдийн засгийн ач тус орон нутагт бараг байхгүйтэй адил. Харин улсын хэмжээнд нь авч үзбэл хотын иргэдэд төсвийн нэгдсэн зохион байгуулалт нь их бага хэмжээгээр ач тустай гэдэг нь тодорч байна.

4.4. Хамаарлын шинжилгээ

4.4.1. Корреляцын шинжилгээ

Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн уул уурхайд хандах хандлага, нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг бүрдүүлэгч хувьсагч хооронд шугаман хамааралтай хүчин зүйлсийн ач холбогдлын түвшинг $P(\text{sig})$ шалгаж үзэхэд “өөртөө итгэх итгэл” нь НУТХЗБ-тай, “гадны хүнд итгэх итгэл” нь ХИ-тэй статистикийн хувьд ач холбогдолгүй байв. “Аминч үзэл” нь ХИ-тэй хүчтэй хамааралтай, ЭЗХЗБ болон НУТХЗБ-тай дунд зэрэг, ИИ-тэй хамаарлын хүч сул байна. “Оролцоо” нь ХИ-тэй хүчтэй хамааралтай байгаа бол НУТХЗБ болон ИИ-тэй урвуу хамааралтай бөгөөд хамаарлын хүч сул байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн оролцоо ихсэх тусам НУТХЗБ, ИИ буурч байна. Үүний цаад шалтгаан нь орон нутгийн иргэд тухайн уул уурхайн үйл ажиллагааны мөн чанарыг танин мэдэх тусам түүний ач холбогдол өөрсдийн нь амьдралд бага ач тустай байгааг мэдснээр нийгэм, улс төр эдийн засгийн хүлээн зөвшөөрөх байдал болон итгэх итгэл буурч, улмаар Үндсэн хуулийн 59-р зүйлийн 2-р заалт буюу төрийн удирдлагыг нутгийн өөрийн удирдлагатай хослуулах зарчим хэрэгжихгүй байгааг илтгэж байна. Энэ нь ашигт малтмалын

тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн оролцоо сул байгааг тодруулж байна. Хэдийгээр иргэдийн оролцоог тодорхой хуулиар олгосон гэдэг хэдий ч бодит амьдрал дээр хэрэгжихгүй байгааг илтгэж байна. “Өөртөө итгэх итгэл” нь НУТХЗБ-тай хамааралгүй байгаа бол ИИ-тэй урвуу хамааралтай, бусад хүчин зүйлстэй хамаарлын хүч сул байна. Харин “гадны хүнд итгэх итгэл” нь ХИ-тэй статистикийн ач холбогдолгүй байгаа бол бусад 3 хүчин зүйлтэй хамаарлын хүч сул байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Улаанбаатар хотын иргэдийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн харилцан корреляцын коэффициент

Хүчин зүйлсийн нэр	ЭЗХЗБ	ХИ	НУТХЗБ	ИИ
Аминч үзэл	.461**	.700**	.401**	.298**
Sig.	.000	.000	.000	.000
Оролцоо	.063*	.672**	-.099**	-.083**
Sig.	.036	.000	.001	.006
Өөртөө итгэх итгэл	.196**	.210**	-.056	-.091**
Sig.	.000	.000	.063	.002
Бусдад итгэх итгэл	.256**	.109**	.805**	.956**
Sig.	.000	.000	.000	.000
Гадны хүнд итгэх итгэл	.185**	0.54	.275**	.246**
Sig.	.000	.074	.000	.000

Тайлбар: Корреляцын коэффициентийн хамаарал хүчтэй байгааг тод ногоон өнгөөр, дунд зэрэг байгааг бүдэг ногоон өнгөөр, сул байгааг шар өнгөөр, статистикийн ач холбогдолгүй байгааг улаан өнгөөр тэмдэглэсэн болно.

Судалгаанд оролцсон Дорнод аймгийн иргэдийн уул уурхайд хандах хандлага, нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьсагч хооронд шугаман хамааралтай хүчин зүйлсийн ач холбогдлын түвшинг P(sig) шалгаж үзэхэд “аминч үзэл” нь нийгмийн лицензийн 4 хүчин зүйлтэй хүчтэй хамааралтай байна. Үүний цаад шалтгаан нь уул уурхайн үйл ажиллагаа иргэдэд шууд ач тустай байх ёстойг илтгэж байна. Харин “Оролцоо” нь эдгээр 4 хүчин зүйлтэй хамаарлын хүч сул байна. “Өөртөө итгэх итгэл” нь ЭЗХЗБ-тай статистикийн ач холбогдолгүй байгаа бол бусад 3 хүчин зүйлтэй урвуу хамааралтай бөгөөд хамаарлын хүч сул байна. Тухайлбал, “өөртөө итгэх итгэл” нь нэмэгдэх тусам ХИ, НУТХЗБ, ИИ буурна гэсэн үг юм. Харин “бусдад итгэх итгэл” нь нийгмийн лицензийн 4 хүчин зүйлтэй статистикийн хувьд ач холбогдолгүй байна. “Гадны хүнд итгэх итгэл” нь ХИ, НУТХЗБ, ИИ-тэй хамаарлын хүч дунд зэрэг байгаа бол ЭЗХЗБ-тай хамаарлын хүч сул байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Дорнод аймгийн иргэдийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн харилцан корреляцын коэффициент

Хүчин зүйлсийн нэр	ЭЗХЗБ	ХИ	НУТХЗБ	ИИ
Аминч үзэл	.429**	.514**	.390**	.314**
Sig.	.000	.000	.000	.000
Оролцоо	.135**	-.136**	-.110*	-.158**
Sig.	.007	.006	.027	.001
Өөртөө итгэх итгэл	.058	-.155**	-.138**	-.213**
Sig.	.243	.002	.005	.000
Бусдад итгэх итгэл	.076	-.017	-.015	-.021
Sig.	.130	.737	.766	.669
Гадны хүнд итгэх итгэл	.210**	.332**	.343**	.363**
Sig.	.000	.000	.000	.000

Тайлбар: Корреляцын коэффициентийн хамаарал хүчтэй байгааг тод ногоон өнгөөр, дунд зэрэг байгааг бүдэг ногоон өнгөөр, сул байгааг шар өнгөөр, статистикийн ач холбогдолгүй байгааг улаан өнгөөр тэмдэглэсэн болно.

4.4.2. Регрессийн шинжилгээ

Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн өгөгдөлд уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлээс хамааран нийгмийн лиценз хэрхэн өөрчлөгдөхийг шинжилж үзэхэд хамаарах болон үл хамаарах хувьсагч хооронд хамааралтай байгаа бөгөөд .795 утгыг илэрхийлж байгаа нь нийгмийн лицензийн өөрчлөлтийн 79.5 хувийг тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн лицензийн өөрчлөлтийн 79.5 хувь нь уул уурхайд хандах хандлагаас хамаарч байна.

Уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч хувьсагчуудын коэффициентийн ач холбогдлын хувьд P(sig) 5 хүчин зүйл статистикийн ач холбогдолтой байна. Монгол хүний уул уурхайд хандах хандлагын “аминч үзэл”-н өөрчлөлтөөс хамааран нийгмийн лиценз нь 0.270, “оролцоо” 0.126, “өөртөө итгэх итгэл” 0.92, “бусдад итгэх итгэл” 0.435, “гадны хүнд итгэх итгэл” 0.048 хазайлттайгаар нэмэгдэнэ. Эдгээр нь уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлс нэг нэгжээр нэмэгдэхэд нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлийн нэмэгдэх хувийг илэрхийлж байгаа юм (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Улаанбаатар хотын иргэдийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүчин зүйлсийн регрессийн шинжилгээний үр дүн

Ангилал	Үл хамаарах хувьсагч	B	SE	t	P		
Нийгмийн лиценз	Тогтмол утга	.236	.121		1.944	.052	.795
	Аминч үзэл	.270	.009	.447	31.335	.000	
	Оролцоо	.126	.008	.218	15.533	.000	
	Өөртөө итгэх итгэл	.092	.017	.076	5.351	.000	
	Бусдад итгэх итгэл	.435	.010	.626	42.522	.000	
	Гадны хүнд итгэх итгэл	.048	.010	.067	4.721	.000	

Дорнод аймгийн иргэдийн өгөгдөлд уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлээс хамааран нийгмийн лиценз хэрхэн өөрчлөгдөхийг шинжилж үзэхэд хамаарах болон үл хамаарах хувьсагч хооронд хамааралтай байгаа бөгөөд .344 утгыг илэрхийлж байгаа нь нийгмийн лицензийн өөрчлөлтийн 34.4 хувийг тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн лицензийн өөрчлөлтийн 34.4 хувь нь уул уурхайд хандах хандлагаас хамаарч байна.

Уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч хувьсагчуудын коэффициентийн ач холбогдлын хувьд P(sig) “оролцоо” 0.604, “бусдад итгэх итгэл” 0.201 байгаа нь статистикийн ач холбогдолгүй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хувьсагчид нийгмийн лицензийн өөрчлөлтийг таамаглахад ач холбогдолгүй байна гэсэн үг юм. Харин монгол хүний уул уурхайд хандах хандлагын “аминч үзэл”-н өөрчлөлтөөс хамааран нийгмийн лиценз нь 0.303, “гадны хүнд итгэх итгэл” 0.215 хазайлттайгаар нэмэгдэнэ. “Өөртөө итгэх итгэл” -0.139 байгаа нь өөртөө итгэх итгэл нэг нэгжээр нэмэгдэхэд нийгмийн лицензийн буурах оноог илэрхийлнэ. Эдгээр нь монгол хүний уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлс нэг нэгжээр нэмэгдэхэд нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын нэмэгдэх хувийг илэрхийлж байгаа юм.

Хүснэгт 20. Дорнод аймгийн уул уурхайд хандах хандлага ба нийгмийн лицензийн хүчин зүйлсийн регрессийн шинжилгээний үр дүн

Ангилал	Үл хамаарах хувьсагч	B	SE	t	P		
Нийгмийн лиценз	Тогтмол утга	2.244	.305		7.351	.000	.344
	Аминч үзэл	.303	.028	.450	10.845	.000	
	Оролцоо	-.020	.038	-.025	-.520	.604	
	Өөртөө итгэх итгэл	-.139	.056	-.139	-2.475	.014	
	Бусдад итгэх итгэл	.063	.049	.069	1.280	.201	
	Гадны хүнд итгэх итгэл	.215	.035	.262	6.136	.000	



4.5. Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үр дүн

Судалгааны үзэл баримтлал, загварчлалын дагуу дөрвөн хүчин зүйлээр ангилж, үнэлгээг тооцож үзэхийн зэрэгцээ 15 шалгуур асуултад хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Нийслэлийн иргэдийн дөрвөн хүчин зүйлийн дундаж үнэлгээ нь 3.89 буюу дундажаас дээгүүр үнэлгээтэй байна. Өөрөөр хэлбэл нийслэлийн иргэдийн амьдралын чанар уул уурхайн үйл ажиллагаанаас шууд бус хамааралтай болох нь харагдлаа. Харин орон нутгийн иргэдийн дөрвөн хүчин зүйлийн дундаж үнэлгээ 3.29 буюу дундажаас доогуур байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн иргэдийн амьдралын чанар уул уурхайн үйл ажиллагаанаас шууд хамааралтай байна. Энэ асуудлыг Дорнод аймгийн Хэрлэн, Баяндун, Дашбалбар, Матад сумын иргэд болон уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс харахад 3.29 гэсэн үнэлгээтэй байгаа нь бататгав.

Иргэдийн хувьд хуулийн хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад дараахь байдлаар оролцох боломжтой. Үүнд, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл авах, уул уурхайн талаар мэдээлэл авах, уул уурхай нь хэрхэн нийгэм, эдийн засгийн ашиг орлогыг нэмэгдүүлэх талаар мэдээлэл авах, өөрийн орон нутагт олгогдсон тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл авах, орон нутагт ашигт малтмалын үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой байгаа компаниудын мэдээлэл авах эрхтэй байдаг. Харин уул уурхайн үйл ажиллагаа эрхлэж байгаа аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл нээлттэй бус, ил тод байдал дутмаг болох нь ярилцлагын явцад харагдлаа. Мэдээлэл хүртээмжгүй, ил тод бус байгаагын улмаас иргэдийн дунд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, орон нутгийн захиргааны төв байгууллагын удирдлагад үл итгэх хандлага давамгайлж байв. Ялангуяа иргэдтэй харилцах эргэх холбоо муу, уул уурхайн үйл ажиллагааны эдийн засгийн үр өгөөж шууд харагдахгүй байгааг онцолж байсан. Үүний шалтгаан нь ашигт малтмалын тухай хуулийн 42.1, 42.2, байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 18.4-р заалтын агуулгаас шууд хамааралтай гэж үзэж болохоор байна.

Шигтгээ 1.

Нээлттэй ил тод байдлаар үйл ажиллагаагаа хийж л байгаа бол дэмжих, өөрөөр хаалттай иргэдийг бухимдуулсан байдлаар хийх нь тохиромжгүй юм шиг санагддаг. Аль болох нээлттэй орон нутгийн засаг дарга, захиргаа мөн адил уг асуудлаар нээлттэй байдлаар, орон нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаатай уул уурхайн компаниуд үүнийгээ нээлттэй байдлаар хийх, хараад байхаар засаг дарга хууль бусаар хувилдах байдлаар болон уул уурхай үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж хоёр хоорондоо тохиролцсон байдлаар хийгээд байгаа юм шиг харагддаг.

Г. А. Дорнод, Хэрлэн сум

Нөгөө талаас уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл нь орон нутгийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллагуудтай харилцахад хүндрэл их гардаг, албан бичгийн хариу хугацаандаа ирдэггүй, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд монгол удирдлагатай уулзахыг хүсдэггүй зэрэг асуудлыг хөндөж байв.

Уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгж нь орон нутгийн түвшинд ашигт малтмалын тухай хуулийн 42.1, 42.2, байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 18.4-р заалт бодит амьдрал дээр муу хэрэгждэг харагдлаа. Тухайлбал, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага иргэдтэй гаргасан шийдврээ хуваалцдаггүй, зөвхөн орон нутгийн төрийн захиргааны байгууллагын удирдлагын түвшинд танилцуулдаг. Иргэд нь энэ тухай мэдээлэл хомс, зарим тохиолдолд олон нийтийн сүлжээнээс мэдээлэл авах түвшинд хязгаарлагдмал, тодорхой чухал шийдвэр, мэдээллүүд ирдэггүй болохыг иргэд онцолж байв. Энэ нь ашигт малтмалын тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хоёр, гуравдугаар бүлэг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэгдүгээр бүлэгт олгогдсон эрхээ хэрхэн ашиглахаа мэддэггүй болох нь харагдлаа.

Шигтгээ 2.

Иргэдтэйгээ хуваалцдаггүй юм байна лээ. Орон нутагт уул уурхайн компани нээгдлээ гэж бодоход аймгийн болон сумын засаг дарга, ЗДТГ, ИТХ, уг асуудлаар холбогдолтой төрийн албаныхантай л уулздаг. Яг иргэдтэйгээ тулж уулздаг гэсэн зүйл бол байхгүй.

Б.О. Дорнод, Хэрлэн сум

Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөллийн зүгээс олон нийтэд үйл ажиллагааны тайлангаа танилцуулдаг гэсэн мэдээллийг өгч байв. Эндээс орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгж хооронд ойлголтын зөрүүтэй байдал ажиглагдаж байв. Өөрөөр хэлбэл, орон нутгийн иргэд тухайн аж ахуйн нэгж үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, тайланг танилцуулах ёстойг мэддэггүй, нөгөө талаас аж ахуйн нэгж нь зөвхөн орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажилладаг байна.

Бутилер болон Блэк нарын үзэл баримтлалд нийгмийн лицензийн мөн чанар нь бүс, орон нутгийн иргэдэд ач тустай байх асуудал гэж үздэг. Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, орон нутгийн иргэдийн хувьд хамтын ажиллагаа төлөвшөөгүй байна. Ярилцлагад хамрагдсан 10 хүний 9 нь уул уурхайн талаар сөрөг ойлголт, хандлагатай байна. Тухайн уул уурхайн компанид ажилладаг иргэн уул уурхайн талаар эерэг төсөөлөлтэй байв. Нас, хүйс, боловсролын түвшин хандлагад ямар ч хамааралгүй болох нь харагдсан. Зөвхөн уул уурхайн үйл ажиллагааг аминч үзлийн хувьд хүлээн зөвшөөрч байгаа байдал харагдсан. Бусдад итгэх итгэл харьцангуй өндөр, гадны хүнд

(гадаадын хөрөнгө оруулагч) итгэх итгэл сул болох нь ярилцлагын явцад харагдлаа.

Нийгмийн лицензийн тухай ойлголт орон нутгийн иргэдэд огт байхгүйн улмаас иргэд уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжид тодорхой шаардлага тавьдаггүй, зөвхөн хувь иргэний хүсэлт илэрхийлэх нь давамгайлдаг байна.

Нийгмийн лицензийн тухай асуудлыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд нарийвчлан заагаагүй учир оролцогч талуудын харилцааны эрх үүрэг тодорхой бус байна. Тухайлбал орон нутагт шинээр уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж эхлэхэд тодорхой бүлэг хүмүүс иргэдийг турхирах үзэгдэл гардаг. Үүнд орон нутгийн иргэд мэдлэг, мэдээлэл хомс учраас бусдад хөтлөгддөг. Иймээс иргэдийг чадавхжуулах, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад иргэдийн оролцоог хангах арга замд сургах, тодорхой мэдлэг ойлголтыг эзэмшүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Шигтгээ 4.

...орон нутагт шинээр уул уурхайн компани нээгдлээ гэж бодоход тодорхой нэг хэсэг бүлэг хүмүүс нь иргэдийн турхирах, учир нь мэдээлэл бүрэн байхгүй учраас. Нэг мэргэшсэн хүн нь болохгүй гэж иргэдэд ойлгуулахад иргэд ойлгож хүлээж авах болно. Орон нутгийн иргэд мэдлэг мэдээлэлгүй учраас тодорхой бүлэг хүмүүст хөтлөгддөг... Иргэдийг маш сайн мэдлэгтэй болгох хэрэгтэй.

Б.О. Дорнод, Хэрлэн сум

Орон нутгийн иргэдийн хувьд нийгмийн лицензийн эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан итгэлцэл шууд хамааралтай болох нь дөрвөн хүчин зүйлийн корелляцийн шинжилгээгээр батлагдсан болно. Энэ тухайд иргэд ярилцлагын явцад уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь ажлын байраа нээлттэй зарлах, нутгийн захиргааны байгууллагатай хийж буй гэрээ нь үр ашигтай байх асуудлыг хөндөж байв.

Шигтгээ 5.

Ямар ч ач тус байхгүй гэж боддог. Уул уурхай эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй засгийн газар нь гэрээ байгуулдаг биш орон нутаг нь сайн гэрээ байгуулдаг байх хэрэгтэй. Засгийн газар нь гэрээ байгууллаа гэхэд манай Дорнод аймагт ашиг тустай зүйл нэг ч гарахгүй байгаа тул орон нутагтаа л татаас нь төвлөрдөг байвал зүгээр юм болов уу.

Э.О. Дорнод, Хэрлэн сум

Орон нутгийн иргэдийн хувьд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжид ажилладаг хэдий ч гадаад мэргэжилтэнтэй харьцуулахад маш бага цалин авдаг. Учир нь цалингийн үнэлгээний ялгаатай байдал иргэдийн ажилд орохын өмнөх, ажилд орсны дараах уул уурхайн үйл ажиллагаанд хандах хандлагад шууд нөлөөлж байна.

Шигтгээ 6.

Би өөрөө Хятад улсад сурдаг хил хаалттай болохоор аргагүйн эрхэнд энд түр ажиллаж байна. Хувь хүнийхээ үүднээс энд ажиллах дур сонирхол байхгүй. Ард иргэдийн байр сууринаас авч үзвэл тэд дуртай байна. Яагаад гэвэл боловсон хүчин ажлын байр хир байгаа билээ тэр талаас нь бодоход, амьдралын төлөө ажиллах хүсэлтэй байна байх.

Г.Б. Дорнод. Хэрлэн сум

Уул уурхайн үйл ажиллагаанд нийгмийн лиценз олгох тухай асуудал нь нийгмийн лицензийн оролцогч талуудын ялгаатай ашиг сонирхол, эрх зүйн орчны зохицуулалт муу, орон нутагт төрийн захиргааны байгууллагын мэдээллийн хаалттай байдал нь иргэдийн оролцоо, байгаль орчноо хамгаалах сэдэл, бусдад итгэх итгэл сул байхад нөлөөлж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ

Байгууллагын үйл ажиллагаа явуулах нийгмийн лиценз гэсэн нэр томъёог 1818 онд английн сүмийн номлогч Жон Уильям Каннингэм хамгийн анх ашигласан бөгөөд харин “нийгмийн лизенц” гэх ойлголтыг судалгааны эргэлтэнд В.Мур болон Жим Куны нар оруулсан байна. 1996 онд Ж.Мур “нийгмийн лиценз” гэсэн ойлголтыг цаас үйлдвэрлэдэг компаниуд “нийгмийн лиценз”-ээ хадгалж үлдэхийн тулд байгаль орчны талаарх дүрэм журмыг давж гарах ёстой гэсэн санаагаар тайлбарлан авч бол Ж.Куни уул уурхайн салбарт “нийгмийн лиценз”-ийг олж авахыг хууль ёсны лицензтэй адилтган, оролцогч талуудын харилцан хамаарал буюу олон нийтийн зүгээс нийтийн сайн сайхан байдалд тухайн бизнесийн үйл ажиллагаа ач тустай байх асуудлыг үндэслэн зөвшөөрч байгаа явдал” хэмээн авч үзсэн. Мэдээж нийгмийн лицензийг судлах нэгдсэн нэг арга зүй хараахан төлөвшөөгүй байна. Энэ судалгааны хүрээнд Я.Томсон, Р.Бутилер нар энэхүү загварыг ашиглан оролцогч талуудын харилцааг институциональ итгэлцэл, харилцан итгэлцэл, эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн дөрвөн хүчин зүйлээр бүлэглэн Блакийн боловсруулсан бүрэн итгэл, зөвшөөрөл олгохуйц, өндөр хүлээн зөвшөөрөлт, дунд зэргийн хүлээн зөвшөөрөлт, хүлээн зөвшөөрөлт бага, түтгэлзэх/хураах үнэлгээний хуваарийг ашиглалаа.

Хэдийгээр Монгол улсад уул уурхайн салбарын хөгжил олон зуун жилээр яригдах боловч 1992 оноос эхлэн хайгуулын болон олборлолтын лицензийг уул уурхай эрхлэгч хувийн хэвшилд олгож эхэлснээр уул уурхайн салбар нь эдийн засгийн эргэлтэд орж, чөлөөт зах зээлийн арилжааны нэг хэсэг болсон. Энэ өмнө байгаагүй уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад тухайн бүс, орон нутгийн төрийн захиргааны байгууллага болон иргэдийн эсэргүүцэл, дарамт шахалт гэсэн шинэ үзэгдэлүүд (phenomena) нийгэмд бий болж эхлэсэн. Энэхүү учир шалтгааныг тодруулах зорилгоор нийгмийн лицензийн арга зүйгээр асуудлыг шалгахдаа түлхүүр хүчин зүйлээр “Монгол хүний уул уурхайд хандах хандлага”-ыг авч үзсэн. Иймээс монгол хүний уул уурхайд хандах хандлага, түүний талаарх мэдлэг, итгэл үнэмшилтэй холбоотой таван хүчин зүйлийг хувьсагчаар хэмжихийг зорьсон. Учир нь “нийгмийн лиценз”-ийн түвшин хоорондын шилжилтийн зааг нь өөрөө тухайн улс үндэстний онцлог шинж, зан үйлтэй холбоотой болохыг судлаачид онцолж байсанд оршино.

Судалгаанд оролцогчдын 1106 нь нийслэлээс, 404 нь Дорнод аймгийн 4 сумын иргэд (Хэрлэн, Баяндун, Дашбалбар, Матад) хамрагдсан. Судалгааны

дүнгээс үзвэл Эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээ нийслэлд 4.87, орон нутагт 4.33 буюу нийслэлийн иргэдийн хувьд эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөр байна. Харилцан итгэлцлийн дундаж үнэлгээ нийслэлд 4.66, орон нутагт 3.18 буюу нийслэлийн иргэдийн харилцан итгэлцэл орон нутгаас харьцангуй өндөр байна. Нийгэм, улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын дундаж үнэлгээ нийслэлд 3.23, орон нутагт 3.04 буюу нийслэлд өндөр байна. Институциональ итгэлцэлийн дундаж үнэлгээ нийслэлд 2.81, орон нутагт 2.62 буюу нийслэлийн иргэд орон нутгаас иргэдээс илүү итгэл хүлээлгэж байна.

Судалгаанд оролцсон иргэдийн үнэлгээгээр институциональ итгэлцэл байхгүйтэй адил байна. Харин Блакийн хуваариар авч үзвэл эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал нийслэлд дунд зэргийн хүлээн зөвшөөрөлттэй буюу арай өндөр байсан. Энэхүү тоон үзүүлэлт нь судалгааны нэгдүгээр асуулт, уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрхлэх нийгмийн лицензийг олж авах нь иргэдийн уул уурхайд хандах хандлагатай шууд хамааралтай байна уу? гэсэн асуултын хувьд тийм гэсэн хариултыг илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл, судалгааны нэгдүгээр асуулт асуулгын анкетээр болон ярилцлагын үр дүнгээр батлагдсан.

Судалгааны хоёрдугаар асуулт буюу нийгмийн лицензийг олж авахад нөлөөлөх гол хүчин зүйлс нь юу болох талаар анкетын үр дүнг Я.Томсон, Р.Бутилер нарын 4 хүчин зүйлээр Улаанбаатар хотын иргэдийн хувьд авч үзвэл “нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “институциональ итгэлцэл” хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь нийгмийн лицензийн зөвшөөрөл олгох түвшин бага, сэтгэл ижилсэх түвшинд хүрэх магадлал бага байгааг илэрхийлж байв. Үлдсэн хэсэг болох “харилцан итгэлцэл” болон “эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байгаа нь нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдалтай байгаа хэдий ч хэлбэлзэх магадлал өндөр байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн лиценз улаан бүсээс ногоон бүс хооронд хэлбэлзэж, хамгийн сайн үед ногоон бүсийн хязгаарт хүрэх боловч хамгийн муу үед улаан бүсийн хязгаарт хүрч цуцлагдах эрсдэлтэй байна (Зураг 22, х. 54).

Харин анкетын судалгааны үр дүнг орон нутагт буюу Дорнод аймагт авч үзвэл зөвхөн “эдийн засгийн хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал”-тай байгаа бөгөөд бусад гурван хүчин зүйл дутагдалтай байна. Энэ нь Дорнод аймагт уул уурхай эрхэлж буй аж ахуй нэгжүүд үндсэндээ санхүүгийн гүйлгээ хийхээс өөр зүйл санал болгодоггүй, иргэд болон оролцогч талуудын зүгээс зөвшөөрлийн түвшинг олгох нь ховор ба сэтгэл ижилсэн түвшинд хүрэх магадлал тун бага байна. Тиймээс голчлон улаан, шар өнгийн бүсэд хүлээн зөвшөөрөгдөх эсвэл хураагдах эрсдэлтэй нөхцөлд байгааг харуулж байна (Зураг 23, х. 55). Эндээс дүгнэлт хийж үзэхэд судлаач Томсон, Бутилер нарын



“нийгэм улс төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал” ба “харилцан итгэлцэл” дээр бага оноо авсан тохиолдолд хэзээ ч “институциональ итгэлцэл” дээр оноо авах боломжгүй гэдгийг баталж байна. Өөрөөр хэлбэл, судалгааны хоёрдугаар асуултын хүрээнд нийгмийн лиценз олж авахад гол нөлөөлж буй хүчин зүйл нь Монгол улсын хувьд эдийн засгийн хүчин зүйл болж байна. Гэхдээ Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт ялгаатай байдал харагдаж байна. Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг Л.Блакийн арга зүй (судалгааны арга 2)-ээр авч үзвэл хотод 3.42, хөдөө 3.15 гэсэн дундаж онооны үзүүлэлт нь хүлээн зөвшөөрөлт бага гэсэн онооны хүрээг харуулж байна. Энэ нь Томсон, Бутилер нарын пирамидын загвараар тайлбарлавал эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай байгааг илэрхийлнэ. Улаанбаатар хотын иргэдийн нийгмийн лицензийн дээрх үзүүлэлтийг Дорнод аймагтай харьцуулахад өндөр байгаа нь хотын иргэд уул уурхайн үйл ажиллагаанаас эдийн засаг, нийгмийн шууд хамаарал багатай байгааг илтгэж байна (Хүснэгт 16, х. 56).

Нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдал түтгэлзэх түвшинг давсан төдий байгаа нь энэ салбарын талаар судалгаанд оролцогчид улсаас зөвшөөрсөн учир хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй мэт ойлголттой байгааг илэрхийлж байна. Үүний шалтгаан нь Монгол улс төрийн байгуулалтын хувьд нэгдмэл тогтолцоотой бөгөөд зөвхөн засаг захиргаа, нэгжийн зохион байгуулалтаар төрийн үйл ажиллагаа эрхлэдэг тул бүс, орон нутгийн ашиг сонирхол уул уурхайн үйл ажиллагаанд тусгалаа олохгүй үлдэх нь төсвийн нэгдсэн тогтолцоонд илэрдэг. Учир нь уул уурхайн үйл ажиллагааны эдийн засгийн ач тус орон нутагт бараг байхгүйтэй адил. Харин улсын хэмжээнд нь авч үзвэл хотын иргэдэд төсвийн нэгдсэн зохион байгуулалт нь их бага хэмжээгээр ач тустай гэдэг нь Ковид-19 цар тахлын үеэр тодорч байна.

Судалгааны гуравдугаар асуултын хүрээнд нийгмийн лицензэд нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан хамааралт байдал нь Монгол улсын хувьд ямар түвшинд байна вэ гэдгийг судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн уул уурхайд хандах хандлага, нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг бүрдүүлэгч хувьсагч хооронд шугаман хамааралтай хүчин зүйлсийн ач холбогдлын түвшинг $P(\text{sig})$ шалгаж үзэхэд “өөртөө итгэх итгэл” нь НУТХЗБ-тай, “гадны хүнд итгэх итгэл” нь ХИ-тэй статистикийн хувьд ач холбогдолгүй байна. “Аминч үзэл” нь ХИ-тэй хүчтэй хамааралтай, ЭЗХЗБ болон НУТХЗБ-тай дунд зэрэг, ИИ-тэй хамаарлын хүч сул байна. “Оролцоо” нь ХИ-тэй хүчтэй хамааралтай байгаа бол НУТХЗБ болон ИИ-тэй урвуу хамааралтай бөгөөд хамаарлын хүч сул байна. Өөрөөр хэлбэл, оролцоо ихсэх тусам НУТХЗБ, ИИ буурна гэсэн үг юм. “Өөртөө итгэх итгэл” нь НУТХЗБ-тай хамааралгүй байгаа бол ИИ-тэй урвуу хамааралтай, бусад хүчин зүйлстэй хамаарлын хүч сул байна. Харин “гадны хүнд итгэх итгэл” нь ХИ-тэй статистикийн ач холбогдолгүй байгаа бол бусад 3 хүчин зүйлтэй хамаарлын хүч сул байна.

Харин орон нутагт буюу Дорнод аймгийн иргэдийн уул уурхайд хандах хандлага, нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын хувьсагч хооронд шугаман хамааралтай хүчин зүйлсийн ач холбогдлын түвшинг $P(\text{sig})$ шалгаж үзэхэд “аминч үзэл” нь нийгмийн лицензийн 4 хүчин зүйлтэй хүчтэй хамааралтай байгаа бол “Оролцоо” нь эдгээр 4 хүчин зүйлтэй хамаарлын хүч сул байна. “Өөртөө итгэх итгэл” нь ЭЗХЗБ-тай статистикийн ач холбогдолгүй байгаа бол бусад 3 хүчин зүйлтэй урвуу хамааралтай бөгөөд хамаарлын хүч сул байна. Тухайлбал, “өөртөө итгэх итгэл” нь нэмэгдэх тусам ХИ, НУТХЗБ, ИИ буурна гэсэн үг юм. Харин “бусдад итгэх итгэл” нь нийгмийн лицензийн 4 хүчин зүйлтэй статистикийн хувьд ач холбогдолгүй байна. “Гадны хүнд итгэх итгэл” нь ХИ, НУТХЗБ, ИИ-тэй хамаарлын хүч дунд зэрэг байгаа бол ЭЗХЗБ-тай хамаарлын хүч сул байна. Эндээс дүгнэлт хийж үзвэл уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч талуудын ялгаатай ашиг сонирхол нь оролцооны шууд болон шууд бус хамааралыг илэрхийлэхийн зэрэгцээ харилцан хамааралт байдал нь хот болон орон нутагт өөр өөр байгааг тодруулж өгсөн.

Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн өгөгдөлд уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлээс хамааран нийгмийн лиценз хэрхэн өөрчлөгдөхийг шинжилж үзэхэд хамаарах болон үл хамаарах хувьсагч хооронд хамааралтай байгаа бөгөөд .795 утгыг илэрхийлж байгаа нь нийгмийн лицензийн өөрчлөлтийн 79.5 хувийг тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн лицензийн өөрчлөлтийн 79.5 хувь нь уул уурхайд хандах хандлагаас хамаарч байна гэсэн үг юм. Уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч хувьсагчуудын коэффициентийн ач холбогдлын хувьд $P(\text{sig})$ 5 хүчин зүйл статистикийн ач холбогдолтой байна. Монгол хүний уул уурхайд хандах хандлагын “аминч үзэл”-н өөрчлөлтөөс хамааран нийгмийн лиценз нь 0.270, “оролцоо” 0.126, “өөртөө итгэх итгэл” 0.92, “бусдад итгэх итгэл” 0.435, “гадны хүнд итгэх итгэл” 0.048 хазайлттайгаар нэмэгдэнэ. Эдгээр нь уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлс нэг нэгжээр нэмэгдэхэд нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын нэмэгдэх хувийг илэрхийлж байв. Харин орон нутагт буюу Дорнод аймгийн иргэдийн өгөгдөлд уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлээс хамааран нийгмийн лиценз хэрхэн өөрчлөгдөхийг шинжилж үзэхэд хамаарах болон үл хамаарах хувьсагч хооронд хамааралтай байгаа бөгөөд .344 утгыг илэрхийлж байгаа нь нийгмийн лицензийн өөрчлөлтийн 34.4 хувийг тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн лицензийн өөрчлөлтийн 34.4 хувь нь уул уурхайд хандах хандлагаас хамаарч байна. Уул уурхайд хандах хандлагыг тодорхойлогч хувьсагчуудын коэффициентийн ач холбогдлын хувьд $P(\text{sig})$ “оролцоо” 0.604, “бусдад итгэх итгэл” 0.201 байгаа нь статистикийн ач холбогдолгүй байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хувьсагчид нийгмийн лицензийн өөрчлөлтийг таамаглахад ач холбогдолгүй байна гэсэн үг юм.

Харин Монгол хүний уул уурхайд хандах хандлагын “аминч үзэл”-н өөрчлөлтөөс хамааран нийгмийн лиценз нь 0.303, “гадны хүнд итгэх итгэл” 0.215 хазайлттайгаар нэмэгдэнэ. “Өөртөө итгэх итгэл” -0.139 байгаа нь өөртөө итгэх итгэл нэг нэгжээр нэмэгдэхэд нийгмийн лицензийн буурах оноог илэрхийлнэ. Эдгээр нь Монгол хүний уул уурхайд хандах хандлагын хүчин зүйлс нэг нэгжээр нэмэгдэхэд нийгмийн лицензийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын нэмэгдэх хувийг илэрхийлж байгаа юм. Эдгээр корреляцын шинжилгээний болон регрессийн шинжилгээний үр дүнг нэгтгэн харьцуулж үзвэл сонгон авсан хандлагын хэмжигдэхүүн нийгмийн лиценз олж авах үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйл болох нь батлагдсан болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол эх сурвалж

П.С.Гуревич. 2004. *Соёл судлал*.

Я.Цэвэл. 2021. *Монгол хэлний товч тайлбар толь*.

П.Доржсүрэн, Я.Бямбасүрэн. 2006. *Төрийн бодлого гарын авлага*.
Улаанбаатар: Удирдлагын академи.

Болд. Н, Батсүх. Ё, Цацралт. Б. 2018. «ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН СУДАЛГАА: Хөгжлийн бодлого, хөтөлбөрийн жишээгээр.» Улаанбаатар: Удирдлагын академи.

Ашигт малтмал газрын тосны газар. 2019. “Геологи, Уул уурхай, Газрын тос, Хүнд үйлдвэрийн салбар эрх зүйн баримт бичгийн эмхтгэл.” Улаанбаатар.

Монгол улс дахь Азийн Сан. 2007. *Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь иргэдийн оролцоо*. Улаанбаатар хот: Азийн сан.

Засгийн газрын 304 тогтоол. 1991. “Алт-1 хөтөлбөр.”

УУБҮБ-ын үнэлгээний цуврал тайлан. 2017. “ЗГХФ уул уурхайн бодлогын үзэл баримтлалын үнэлгээ: Монгол Улс.”

Үндэсний статистикийн хороо. 2020. “2020 оны 3-р улиралын тайлан.”

Гадаад эх сурвалж

Black, Leeora. 2013. *The Social License to Operate*.

—. 2013. *The social license to operate: Your management framework for complex times*. London: 2013.

Boutilier, Robert. 2017. “A Measure of the Social License to Operate for Infrastructure and Extractive Projects.”

Cooney, Jim. 2017. “Reflections on the 20th anniversary of the term “social license”.” *Journal of Energy & Natural Resources Law* 197-200.

Geert Demujink, Björn FASTERLING. 2016. “The Social License to Operate.” *Journal of Business Ethics* 675-685.

Ian Thomson, Joyce Susan. 2008. “The social license to operate: what it is and why it seems so hard to obtain.” (Paper presented at the 2008 Prospectors and Developers Association of Canada Convention).

Ian Thomson, Robert G. Boutilier. 2011. “Modeling and Measuring the Social License to Operate: Fruits of Dialogue Between Theory and Practice.”

Industrie- und Handelsbericht in Bayern, Aussenwirtschaft Austria. April 2019. *Exportbericht Mongolei*.

Joel Gehman, Lianne Lefsrud, Stewart Fast. 2017. “Social License to Operate: Legitimacy by Another Name.” *Canadian Public Administration* 293-317.

Joyce, Thomson. 2000. “Earning a social license to operate: Social

acceptability and recourse development in Latin America.” *The Canadian mining and metallurgical bulletin*.

Komnitsas, Konstantinos. 2020. “Social License to Operate in Mining: Present views and future trends.” *School of Mineral Resources Engineering, Technical University Crete*.

M. Fishbein, I. Ajzen. 1975. *Belief, attitude, intention and behavior: An introduction to theory and research*.

Merriam-Webster. 1928. *Knowledge, Perception, Selfishness*.

Moore, W. H. 1996. “The social license to operate.” *PIMA magazine* 22-23.

Morrison, John. 2014. *The social license: How to keep your organization legitimate*.

Robert G. Boutilier, Ian Thomson. 2011. “Modelling and Measuring the Social License to Operate: Fruits of a Dialogue Between Theory and Practice.”

T. Golivich, D. Keltner, S. Chen, Richard E. Nisbett. 2013. *Social Psychology*.

ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНЫ АНКЕТ

Q. ШҮҮЛТҮҮР АСУУЛТУУД

Та эхлээд дараах цөөн асуултанд дугуйлж хариулт өгнө үү.

Q1	Та хэдэн настай вэ?	<ol style="list-style-type: none"> 1. 18-аас доош 2. 18-29 3. 30-44 4. 45-64 5. 65+
Q2	Хүйс	<ol style="list-style-type: none"> 1. Эрэгтэй 2. Эмэгтэй
Q3	Таны боловсролын түвшин	<ol style="list-style-type: none"> 1. Боловсролгүй 2. Бага боловсролтой 3. Бүрэн бус дунд 4. Бүрэн дунд 5. Мэргэжлийн ба техникийн 6. Бакалавр 7. Магистр 8. Доктор
Q4	Та ажил эрхэлдэг үү?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм (бүтэн цагийн) 2. Тийм (хагас цагийн) 3. Ажилгүй (ажил хайж байгаа) 4. Ажилгүй (ажил хайгаагүй) 5. Оюутан 6. Тэтгэвэрт 7. Гэртээ өвчтэй хүн асардаг 8. Гэртээ хүүхдээ хардаг 9. Бусад
Q5	Таны ажилладаг байгууллагын хариуцлагын хэлбэр	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн захиргааны байгууллага 2. Төрийн үйлчилгээний байгууллага 3. Төрийн өмчит компани 4. Цэргийн алба 5. Хувийн аж ахуйн нэгж 6. Гадаад хөрөнгө оруулалттай компани 7. Хувиараа хөдөлмөр эрхлэгч 8. Төрийн бус байгууллага 9. Олон улсын байгууллага 10. Малчин 11. Фермер 12. Бусад (дэлгэрүүлнэ үү
Q6	Оршин суугаа нутаг дэвсгэр	<ol style="list-style-type: none"> 1.Хот 2.Хөдөө 3.Хилийн чанад



А. УУЛ УУРХАЙН ТАЛААРХ ХАНДЛАГА, ОЙЛГОЛТ

Та дараах асуултуудад санал нийлж буй байдлаа 1-7 онооны хооронд үнэлж хариулна уу.

	Асуулт	Санал огт нийлэхгүй байна						Санал маш их нийлж байна
		(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)
A1	Уул уурхайн талаар би сайн мэднэ	1	2	3	4	5	6	7
A2	Уул уурхайн талаар монголчууд сайн мэднэ	1	2	3	4	5	6	7
A3	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь надад ашигтай	1	2	3	4	5	6	7
A4	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагаа явагдах нь иргэн бүрд ашигтай	1	2	3	4	5	6	7
A5	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд надаас асуух ёстой	1	2	3	4	5	6	7
A6	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд орон нутгийн бүх иргэдээс асуух ёстой	1	2	3	4	5	6	7
A7	Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд Монгол улсын иргэн бүрээс асуух ёстой	1	2	3	4	5	6	7
A8	Би байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг хүн	1	2	3	4	5	6	7
A9	Монголчууд байгаль орчноо хайрлан хамгаалж, дээдлэн хүндэлдэг ард түмэн	1	2	3	4	5	6	7
A10	Би өөртөө итгэдэг	1	2	3	4	5	6	7
A11	Би гэр бүлдээ итгэдэг	1	2	3	4	5	6	7
A12	Би төрөл садандаа итгэдэг	1	2	3	4	5	6	7
A13	Би найз нөхөддөө итгэдэг	1	2	3	4	5	6	7
A14	Би хамт олондоо итгэдэг	1	2	3	4	5	6	7
A15	Би танихгүй хүнд итгэдэг	1	2	3	4	5	6	7
A16	Би гадны улс үндэстэнд итгэдэг	1	2	3	4	5	6	7

В. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НИЙГЭМ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ БАЙДАЛ

Та дараах асуултуудад санал нийлж буй байдлаа 7-1 онооны хооронд үнэлж хариулна уу.

	Асуулт	Санал маш их нийлж байна						Санал огт нийлэхгүй байна
		(7)	(6)	(5)	(4)	(3)	(2)	
B1	Бид уул уурхайн компанитай харилцах харилцаагаа өргөжүүлж чадна	7	6	5	4	3	2	1
B2	Бид хамгийн чухал зорилгодоо хүрэхийн тулд уурхайн компанитай хамтын ажиллагаатай байх хэрэгтэй	7	6	5	4	3	2	1
B3	Уул уурхайн компаниуд бидэнтэй хамтын ажиллагааныхаа хүрээнд хийх зүйлээ л хийдэг	7	6	5	4	3	2	1
B4	Бид уул уурхайн компаниудтай харилцах харилцаандаа сэтгэл хангалуун байна	7	6	5	4	3	2	1
B5	Уул уурхайн компаниуд байгаа нь бидэнд ашигтай	7	6	5	4	3	2	1
B6	Уул уурхайн компаниуд нь биднийг сонсдог	7	6	5	4	3	2	1
B7	Урт хугацаандаа уул уурхайн компаниуд бүс нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулна гэж бодож байна	7	6	5	4	3	2	1
B8	Уул уурхайн компаниуд нь бидэнд шударга ханддаг	7	6	5	4	3	2	1
B9	Уул уурхайн компаниуд нь олон нийтийн хийж буй зүйлсэд хүндэтгэлтэй ханддаг	7	6	5	4	3	2	1
B10	Уул уурхайн компаниуд бүс нутгийн ирээдүйн талаар бидэнтэй адил алсын хараатай байдаг	7	6	5	4	3	2	1
B11	Уул уурхайн компаниуд бидэнд хамаатай гаргасан шийдвэрээ хуваалцдаг	7	6	5	4	3	2	1
B12	Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхлыг харгалзан үздэг	7	6	5	4	3	2	1
B13	Уул уурхайн компаниуд бидний ашиг сонирхолд санаа тавьдаг	7	6	5	4	3	2	1



B14	Уул уурхайн компаниуд бидэнтэй холбоотой мэдээллийг нээлттэй хуваалцдаг	7	6	5	4	3	2	1
B15	Уул уурхайн компаниуд нь тэдний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй буй иргэдэд илүү их дэмжлэг үзүүлдэг	7	6	5	4	3	2	1

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА